



НЭЭЛТТЭЙ
НИЙГЭМ
ФОРУМ



ДОТООД
ХЭРГИЙН
ИХ СУРГУУЛЬ

ЦАГДААГИЙН АЛБА ХААГЧДЫН АЖИЛ ДҮГНЭХ ҮЗҮҮЛЭЛТ ХҮНИЙ ЭРХИЙН ЗАРЧИМД НИЙЦЭЖ БУЙ ЭСЭХ

СУДАЛГААНЫ ТАЙЛАН

Улаанбаатар хот
2020 он

ННА 67.3
ДАА 340.009
Э-739

**ЦАГДААГИЙН АЛБА ХААГЧДЫН
АЖИЛ ДҮГНЭХ ҮЗҮҮЛЭЛТ ХҮНИЙ ЭРХИЙН
ЗАРЧИМД НИЙЦЭЖ БУЙ ЭСЭХ**

Судалгааны багийн ахлагч: Д.ЭРДЭНЭБААТАР, Хууль зүйн доктор (Ph.D)

Судлаачид: М.ЭРДЭНЭБАЯР, Хууль зүйн доктор (Ph.D)

Г.БЯМБАДОРЖ, ХСИС-ийн докторант

Ч.ДОРЖСҮРЭН, ХСИС-ийн докторант

А.БАТСАЙХАН, Хууль зүйн магистр

© Нээлттэй Нийгэм Форум, 2020 он
Уг тайланг ашиглахдаа эх сурвалжийг дурдана уу.

Хаяг: Жамьяан гүний гудамж

Сүхбаатар дүүрэг

Улаанбаатар 14240

Утас: 976-11-313207

Факс: 976-11-324857

Веб: <http://www.forum.mn>

И-мэйл: osf@forum.mn

ISBN 978-9919-9574-8-3

АГУУЛГА

НЭГ. УДИРТГАЛ	4
1.1. Судалгааны ажлын зорилго, цар хүрээ	4
1.2. Судалгааны арга зүй, аргачлал	4
1.3. Сэдвийн судлагдсан байдал	5
ХОЁР. СУДАЛГААНЫ ДҮН	10
2.1. Цагдаагийн албаны тухай хууль, Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журамд алба хаагчийн ажил дүгнэх үзүүлэлт, хүний эрхийн зарчим тусгагдсан эсэх	10
2.2. Цагдаагийн алба хаагчдын ажил дүгнэх үзүүлэлтийн дүн шинжилгээ	14
2.3. Ажил дүгнэх үзүүлэлтийн талаарх цагдаагийн алба хаагчдын үнэлгээ, дүгнэлт	26
2.4. Цагдаагийн алба хаагчийн эрхийн хэрэгжилт	49
ДҮГНЭЛТ	60
САНАЛ, ЗӨВЛӨМЖ	65
АШИГЛАСАН МАТЕРИАЛ	71

УДИРТГАЛ

1.1. Судалгааны ажлын зорилго, цар хүрээ

Цагдаагийн мэргэжлийн албаны чиг үүрэг, ажлын байрны тодорхойлолтод тусгагдсан ажил үүргийн хуваарь, алба хаагчийн ажил дүгнэх шалгуур үзүүлэлт нь хүний эрхийн зарчимд нийцэж байгаа эсэхэд дүн шинжилгээ хийж, эерэг болон сөрөг талыг үнэлэн дүгнэж, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар санал, зөвлөмж боловсруулахыг зорилоо. Судалгаанд төв, орон нутгийн цагдаагийн газар, хэлтсийн гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам сахиулах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах албаны алба хаагчдыг хамрууллаа.

1.2. Судалгааны арга зүй, аргачлал

Төслийн баг *Institute for Economics and Peace (IEP)*, *International Police Science Association (IPSA)*, *UN Office of the High Commissioner for Human Rights* зэрэг олон улсын байгууллагаас гаргасан “*World internal security and police index*”, “*The assessing the performance index*”-ийг орчуулан, цагдаагийн алба хаагчдын ажил дүгнэх шалгуур үзүүлэлтэд тусгавал зохих үзүүлэлтийг боловсруулан гаргав. Мөн цагдаагийн байгууллагын алба хаагчдын ажил дүгнэх үзүүлэлтэй холбоотой мөрдөгдөж буй дараах хууль тогтоомжийг судалж дүн шинжилгээ хийлээ. Үүнд:

- Монгол Улсын Үндсэн хууль;
- Монгол Улсын нэгдэн орсон Хүний эрхийн олон улсын гэрээ, конвенц;
- НҮБ болон ОУ-ын Хүний эрхийн байгууллагаас гаргасан хүний эрхийг хангах талаарх стандарт, зөвлөмж;
- ХЭҮК-ын Хүний эрх, эрх чөлөөний ээлжит илтгэлүүд;
- Цагдаагийн албаны тухай, Төрийн албаны тухай, Хөдөлмөрийн хууль болон бусад эрх зүйн актууд;
- Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журмын Эмхэтгэл, Цагдаагийн газар, хэлтсийн ажлын тайлан мэдээ;

- Алба хаагчийн ажил дүгнэх үзүүлэлт, ажлын ачаалал, хөдөлмөрийн харилцааны чиглэлээр бичигдсэн эрдэм шинжилгээний зохиол, бүтээл.

Цагдаагийн алба хаагчийн ажил дүгнэх үзүүлэлт нь хүний эрхийн зарчимд нийцэж байгаа эсэх, ажлыг бодитой дүгнэх арга хэлбэр, шалгуур шаардлагыг харьцуулан судлах, үр дүнг тодорхойлох зорилгоор тусгайлан бэлтгэсэн анкетын асуултын дагуу Улаанбаатар хотын дүүргүүдийн цагдаагийн хэлтэс, тасгийн болон орон нутаг (нийт 19 аймаг)-ийн цагдаагийн газар, хэлтсийн алба хаагчдаас асуулга авч, үр дүнг нэгтгэн гаргалаа. Тэрчлэн, тоон судалгаагаар төдийлөн илрүүлэх боломжгүй асуудлыг тодруулах, алба хаагчдын ажил дүгнэх үзүүлэлтийг бодитой үнэлэх зорилгоор ганцаарчилсан болон бүлгийн ярилцлагын аргыг мөн ашиглав. Энэ хүрээнд удирдах албан тушаалтан буюу алба хаагчдын ажил дүгнэх түвшний удирдлагууд болон гүйцэтгэх албан тушаалд ажиллаж байгаа нийт 15 хүнтэй чөлөөт сурвалжилга хийлээ.

Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журмуудаас хүний эрхтэй шууд болон дам байдлаар уялдаж буй 134 журмыг Хүний эрхийн түгээмэл тунхаглал болон Монгол Улсын Үндсэн хуульд заасан хүний эрхийн заалтуудтай харьцуулан судалж, гаргасан шалгуурт нийцүүлэн түүврийн аргаар сонгож авсан болно. Мөн санамсаргүй түүврийн аргыг ашиглан цагдаагийн байгууллагад ажиллаж буй бүх шатны алба хаагчдын бүлэг үүсгэн фокус ярилцлагад хамруулав.

1.3. Сэдвийн судлагдсан байдал

Цагдаагийн алба хаагчдын төрөл мэргэжлийн албаны чиг үүрэг, ажлын байрны тодорхойлолтод тусгагдсан ажил үүргийн хуваарь, алба хаагчийн ажил дүгнэх үзүүлэлт нь хүний эрхийн зарчимд нийцэж байгаа эсэх талаар урьд өмнө ямар судалгааны ажил хийгдэж байсан, тэдгээр нь ямар түвшинд хийгдсэн зэрэгт дүн шинжилгээ хийв. Улмаар бидний судлахыг зорьж буй судалгааны ажилтай тэдгээр нь хэрхэн холбогдох, ямар шинэ мэдлэг бий болгохыг (судалгааны шинэлэг талыг) харуулах зорилгоор контекст судалгааны тоймыг бэлтгэлээ.

Сэдвийн судлагдсан байдал буюу өмнөх судалгаануудыг хайх параметрыг тогтоохдоо хууль зүйн шинжлэх ухааны эрдэм шинжилгээний илтгэл, өгүүлэл нийтлэгддэг нэр хүнд бүхий “Монголын төр эрх зүй”¹, “Эрх зүй”², “Гэмт явдалтай тэмцэх асуудал”³, “Өмгөөлөгч”⁴, “Хууль дээдлэх ёс”⁵, “Хууль сахиулахуй”, “Цагдаа судлал” зэрэг эрдэм шинжилгээний болон Хүний эрхийн Үндэсний комиссоос эрхлэн гаргадаг “Хүний эрх”⁶ сэтгүүл, болон бусад судалгаа, Хууль зүйн Үндэсний хүрээлэн, Нээлттэй Нийгэм Форум, Хууль сахиулахын их сургуулийн Эрдэм шинжилгээ хөгжлийн хүрээлэнгийн 2012-2016 оны эрдэм шинжилгээний тайлан, Хууль зүйн бүтээлийн цахим сан⁷, Шинжлэх ухаан технологийн сангийн номын сан зэрэгт хадгалагдаж буй судалгааны ажлын тайлан, эрдмийн зэрэг горилсон бүтээл, цагдаа судлал болон хүний эрхийн чиглэлээр бичигдсэн ном сурах бичиг, нэг сэдэвт бүтээл, магистрын дипломын ажил зэрэг 1000 гаруй бүтээлийг сонгон түүнд хайлт хийж судлагдсан байдлыг тодорхойлохыг оролдов. Энэ хүрээнд 1995 оноос хойших 10 гаруй жилийн хугацаанд нийтлэгдсэн бүтээлд дүн шинжилгээ хийлээ.

Контекстын тоймын үр дүнд бидний судлах гэж буй сэдэвтэй шууд холбоо бүхий дараах мэдээлэл тэмдэглэгдэн үлдсэн ба түүнийг сийрүүлэн үзвэл: Монгол Улсын Ерөнхийлөгч Н.Багабанди хууль сахиулах төв, орон нутгийн байгууллагын удирдах ажилтны нэгдсэн зөвлөгөөн дээр *“шүүх, прокурор, цагдаагийн ... ажилтан нэг бүрийн ажлыг тодорхой хугацаанд дүгнэж, үнэлэлт өгч, ажлын үр дүнг цалин, зэрэг дэв, шагнал урамшуулалтай холбох арга хуулийн байгууллагад тэр бүр хэвиээгүй”*⁸ байгаа талаар зарчмын дүгнэлт хийж, ажлыг үр дүнтэй нь холбон бодитой дүгнэж байх үүрэг хэрэгжүүлэхийг даалгаж байжээ. Үүнээс үзэхэд цагдаагийн байгууллагын ажилтны ажлыг дүгнэх, шагнах урамшуулах асуудал нь 20-иод жилийн өмнөөс анхаарал татсан асуудлын нэг байсныг илэрхийлнэ.

¹ 1995 оноос эхлэн гарсан

² 2000 оноос

³ 2002 оноос

⁴ 2006 оноос

⁵ 2008 оноос

⁶ Хүний эрхийн Үндэсний комиссоос эрхлэн 2002 оноос эхлэн улирал тутамд гардаг сэтгүүл

⁷ <http://legaldata.mn/>нийт 247 бүтээл.

⁸ Монгол Улсын Ерөнхийлөгч Н.Багабандийн хууль сахиулах төв, орон нутгийн байгууллагын удирдах ажилтны нэгдсэн зөвлөлгөөн дээр тавьсан “Бусдад учруулсан хохирлыг заавал нөхөн төлүүлж байх ёстой” илтгэл. Шинэ зууны өмнөх бодлого, зорилт. Эмхэтгэл. УБ., 1998. 68 дахь тал.

Монгол Улс НҮБ-д гишүүнээр элсэж, Хүний эрхийн түгээмэл тунхаглал, хүний эрхийн бусад баримт бичгийг бүрэн хүлээн зөвшөөрч, Үндсэн хуульдаа (1992) хүний эрхийг баталгаажуулснаас хойш хүний эрхийн зарчим, хэм хэмжээ, стандартыг хангах зорилгоор “эрхэд суурилсан хөгжлийн хандлага”⁹-ыг аливаа хөгжлийн бодлого, төлөвлөлт, үйл явц, хууль тогтоомж, дүрэм журамд баримтлахыг чухалчлах болов. Тиймээс УИХ-ын 2003 оны 10 дугаар сарын 24-ний өдрийн 41 дүгээр тогтоолоор “Монгол Улсад Хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөр”-ийг баталсан. Энэхүү хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар тухайн жилд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, түүний үр дүнг Засгийн газрын гишүүний эрхлэх асуудлын хүрээ болон аймаг, нийслэлийн хэмжээгээр гаргаж, үнэлэлт, дүгнэлт өгсний үндсэн дээр төрийн захиргааны төв байгууллага, аймаг, нийслэлийн засаг дарга нарын ажлыг дүгнэх нэг үндсэн үзүүлэлт болгох талаар тогтоолын 2 дахь хэсэгт тодорхой дурдсан байдаг. Үүгээр аливаа төрийн байгууллагын ажил дүгнэх үндсэн гол шалгуурыг хүний эрхийг хэрхэн хангасан, хүний эрхийн зөрчил гаргаагүй байх хэмээн тогтоожээ.

Түүнчлэн, хөтөлбөрийн хоёрдугаар бүлгийн 2.1.2.10-д “Хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, шүүгч прокуроруудын ажлыг дүгнэх, алдар цол, одон медалиар шагнах, албан тушаалд дэвшүүлэхэд хүний халдашгүй эрхийн талаар алдаа зөрчил гаргаж байсан эсэхийг холбогдох байгууллага, албан тушаалтан заавал харгалзан үзэж байх шалгуур журам тогтоож мөрдүүлнэ” гэж заажээ. Энэхүү заалт нь бидний судлах гэж буй судалгааны ажлын эрх зүйн болоод үндсэн судлагдахуун болно.

Хүний эрхийн хөтөлбөрийн хороо нь тус хөтөлбөрийн хэрэгжилт болон төлөв байдлын талаар судалгаа, дүн шинжилгээ хийх бүрэн эрхтэй боловч одоо хүртэл бидний судлах гэж буй 2.1.2.10 заалтаар тухайлсан судалгаа, дүн шинжилгээний¹⁰ ажил хийгдээгүй байна. Харин хэрэг

⁹ Эрхэд суурилсан хөгжлийн хандлага нь хүний эрхийг хангах, хамгаалах зорилго бүхий олон улсын хүний эрхийн стандартад нийцсэн хүний хөгжлийн үйл явцын тухай үзэл баримтлал юм. НҮБ-аас баталсан Хөгжих эрхийн тухай тунхаглалд зааснаар “хөгжил” гэдэг нь нийт иргэд, хувь хүмүүсийн идэвхтэй, чөлөөт оролцоонд үндэслэн гарч буй үр ашгийг шударгаар хуваарилах, бүх нийтийн сайн сайхан байдлыг хангах зорилго бүхий улс төр, эдийн засаг, нийгэм соёлын цогц үйл явц мөн хэмээн тодорхойлжээ.

¹⁰ Монгол Улсын Засгийн газрын 2005 оны 167 дугаар тогтоолын 1-р хавсралтаар батлагдсан “Монгол Улсад Хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөрийн хорооны дүрэм” Гурав. Хорооны бүрэн эрх. 3.1.13. судалгааны байгууллага, судлаачдаар хүний эрхийн асуудлаар судалгаа, боловсруулалтын ажил гүйцэтгүүлж, хяналт шинжилгээ хийлгэх ажил зохион байгуулах.

бүртгэх албаны удирдах ажилтны зөвлөгөөний (2005) үеэр тавьсан илтгэлд уг заалтыг хэрэгжүүлэх хэрэгцээ шаардлагын талаар “Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаанд гарч буй хүний эрхийн зөрчил нь хуулийн байгууллагад дотооддоо мөрддөг дүрэм заавартай бас холбоотой байдаг. ...тус албанд мөрдөж буй ажил дүгнэх, цалин хөлс олгох, шагнал урамшилд тодорхойлох, цол хэргэм нэмэх зэрэгт хууль дүрмийг хэрхэн биелүүлсэн, хүний эрхийн зөрчил гаргасан эсэхийг гол үзүүлэлт болгон үздэг байх ёстой”¹¹ гэж дурджээ.

Мөн мөрдсөн, илрүүлсэн, торгосон, шийтгэсэн, ялласан, баривчилсан зэрэг тоон үзүүлэлтийг хэт үнэлэх нь эцэстээ хүний эрх зөрчигдөхөд түлхэц болдог талаар дурдаж “манай удирдлагын менежмент нь хэрэг бүртгэх албаны болон алба хаагчдын гүйцэтгэх үүргийг оновчтой тогтоох, ажлын байрны тодорхойлолтыг цаг үеийн шаардлагад нийцүүлэн шинэчлэх, хүний хөгжлийн цогц хөгжлийг хангах, тэдний ажлыг бодитой шударга үнэлэх, хөдөлмөр зохион байгуулалтыг боловсронгуй болгох... зэрэг асуудлуудад чиглэгдэх ёстой”¹² гэж зорилтоо тодорхойлж байжээ.

Цагдаагийн байгууллагаас сахилга хариуцлагыг сайжруулах, ажил дүгнэх талаар “Сахилга дэг журам, ажлын хариуцлагыг сайжруулах тухай” Засгийн газрын 2007 оны 13 дугаар албан даалгаврыг хэрэгжүүлэх, Төрийн албаны зөвлөлийн 2007 оны 48 дугаар тогтоолын дагуу алба хаагчдын үр дүнгийн гэрээ, ажлын байрны тодорхойлолтыг хариуцсан ажил үүргийн чиглэлээр нь төрөлжүүлэх, 2008-2010 онд хэрэгжүүлэх “Цагдаа, дотоодын цэргийн алба хаагчдын сахилга ёс зүйг дээшлүүлэх хөтөлбөр” боловсруулж, хэрэгжүүлэх ажлын хэсгийг ЦЕГ-ын даргын 2008 оны 93 дугаар тушаалаар байгуулж, ХЗДХ-ийн сайдын 2008 оны 47 дугаар тушаалаар “цагдаагийн алба хаагчдыг зөрчлийн улмаас оноосон торгуулийн мөнгөний хувиар байгууллага, алба хаагчдыг урамшуулдаг, санхүүжүүлдэг, торгууль ногдуулах төлөвлөгөө, даалгавар өгдөг,

¹¹ Хүний эрхийн Үндэсний комиссын гишүүн Ж.Дашдорж. “Хүний эрх - хэрэг бүртгэх ажиллагаа” сэдэвт Хэрэг бүртгэх албаны удирдах ажилтны нэгдсэн зөвлөлгөөн дээр тавьсан илтгэл. Хэрэг бүртгэх ажиллагаа. Эмхэтгэл. УБ., 2005. 15 дахь тал

¹² Хэрэг бүртгэх газрын дарга, цагдаагийн хурандаа Л.Сүхээ. Хүний эрх - цагдаагийн хэрэг бүртгэлт (“Хүний эрх - хэрэг бүртгэх ажиллагаа” сэдэвт Хэрэг бүртгэх албаны удирдах ажилтны нэгдсэн зөвлөлгөөн дээр тавьсан илтгэл). Хэрэг бүртгэх ажиллагаа. Эмхэтгэл. УБ., 2005. 16 дахь тал

түүгээр ажил дүгнэдэг асуудлыг таслан зогсоох, бүх шатны удирдах ажилтны хяналт, мэргэжлийн туслалцааг алба хаагчдын сахилга, ёс зүйг дээшлүүлэхэд чиглүүлж, аливаа шагнал урамшуулал, албан тушаалд дэвшүүлэхэд хүний эрхийг хангах талаар хэрхэн ажилласан, хүний эрхийн зөрчил, дутагдалгүй ажилласан байдлыг гол шалгуур болгон хэвшүүлэн ажиллаж байгаа”¹³ талаар цөөнгүй мэдээлэл байна.

Түүнчлэн “цагдаа шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагаас хохирогчийн эрхийг хамгаалах хөндөгдсөн эрхийг сэргээх талаар хийж байгаа ажлыг тэдгээр байгууллагын ажлын үр дүнг үнэлэх шалгуурт оруулж дүгнэх, хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын шатанд гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг нөхөн төлүүлэх, гэм буруутай этгээдийн хөрөнгийг битүүмжлэх, хамгаалах, нуугдмал эд хөрөнгө, мөнгийг илрүүлэх ажлын үр дүнг алба хаагч, нэгжийн ажлыг дүгнэх үндсэн үзүүлэлт болгон сар бүр дүгнэж хохирол нөхөн төлүүлэх ажиллагаанд тасгийн дарга нар байнга хяналт тавин ажиллаж байгаа”¹⁴ тухай ч ХЗДХЯ-ны төрийн нарийн бичгийн даргын илтгэлд дурдагдаж байжээ.

Дээрхээс дүгнэхэд гэмт хэрэгтэй тэмцэх, мөрдөн шалгах чиг үүрэг бүхий цагдаагийн алба хаагчийн ажлыг дүгнэхдээ хууль сахиулах ажиллагааны явцад хүний эрхийг зөрчсөн үйлдэл гаргасан тохиолдолд үнэлгээг бууруулах хандлага ажиглагдаж байна. Эцэст нь цагдаагийн байгууллагын алба хаагчдын ажил дүгнэх үзүүлэлтэд хүний эрхийн суурь зарчмууд хэрхэн тусгагдсан талаар эрдэм шинжилгээ судалгааны байгууллага, судлаачдаас тухайлан судлаагүй бөгөөд зөвхөн практик байгууллагын ажлын хэрэгцээ шаардлагын хүрээнд илтгэл, нийтлэл, мэдээлэл гаргах хэмжээнд байна.

¹³ Хүний эрхийн түгээмэл тунхаглал батлагдсаны 60 жилийн ойн хүрээнд Хүний эрх, эрх чөлөөг хангах талаар хийсэн ажлын талаарх цагдаагийн ерөнхий газрын мэдээлэл. Хүний эрх сэтгүүл. 2008 №3

¹⁴ Хохирогчийн эрхийн баталгаа сэдвээр зохион байгуулсан үндэсний чуулганаас гаргасан зөвлөмжийн хэрэгжилт, үр дүн. ХЗДХЯ-ны төрийн нарийн бичгийн дарга Г.Баясгалангийн илтгэл. Хүний эрх сэтгүүл. 2008 №4

Хоёр. СУДАЛГААНЫ ДҮН

2.1. Цагдаагийн албаны тухай хууль, Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журамд алба хаагчийн ажил дүгнэх үзүүлэлт, хүний эрхийн зарчим тусгагдсан эсэх

Судалгааны ажлын хүрээнд Цагдаагийн албаны тухай хуульд хүний эрхийн зарчмыг хэрхэн тусгасан талаар судалж дүн шинжилгээ хийхдээ Олон улсын гэрээ болон Монгол Улсын Үндсэн хуульд заасан хүний эрхтэй холбоотой зүйл, заалтуудыг иш үндэс болголоо. Цагдаагийн албаны тухай хуульд хүний эрхийн зарчим, хэм хэмжээ хэрхэн туссаныг харьцуулан авч үзлээ.

Цагдаагийн албаны тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д “Цагдаагийн алба, алба хаагч нь үйл ажиллагаандаа Монгол Улсын Үндсэн хуульд зааснаас гадна хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэх, ил тод, нээлттэй байх... зарчмыг баримтална”, 5.4-т “Цагдаагийн алба хаагч дээд шатны цагдаагийн байгууллага, албан тушаалтны гаргасан хууль бус шийдвэрийг биелүүлэхээс татгалзаж, үндэслэлээ тайлбарлах эрхтэй”, 5.5-д “Цагдаагийн байгууллага, алба хаагчаар хуульд зааснаас өөр ажил, үүрэг гүйцэтгүүлэхийг хориглоно” гэж тус тус заасан нь алба хаагчдаар хуульд заагаагүй үүрэг гүйцэтгүүлэх, тэднийг хууль бус үйлдэл, үйл ажиллагаа явуулахгүй байх нөхцөлийг хангасан зохицуулалт болжээ.

Судалгааны ажлын хүрээнд Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журамд алба хаагчдын ажил дүгнэх үзүүлэлт хэрхэн туссан болон хүний эрхийн чиглэлээр хэрэгжүүлж байгаа үйл ажиллагааг авч үзэхийг зорилоо. Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журмыг хууль тогтоомжид нийцүүлэн ЦЕГ-ын даргын тушаалаар баталдаг бөгөөд уг журам нь 9 бүлэг 236 журамтай бөгөөд бүлэгт тус бүр нь цагдаагийн байгууллага, алба хаагчийн төрөл, үйл ажиллагааг зохицуулсан байна. Үүнд:

- Нэгдүгээр бүлэг. Цагдаагийн байгууллагын удирдлага, зохион байгуулалт;
- Хоёрдугаар бүлэг. Алба хаагчийн нийтлэг үйл ажиллагаа;

- Гуравдугаар бүлэг. Гэмт хэрэг илрүүлэх, мөрдөх ажиллагаа;
- Дөрөвдүгээр бүлэг. Нийтийн хэв журам хамгаалах;
- Тавдугаар бүлэг. Олон нийтийн аюулгүй байдлыг хангах;
- Зургадугаар бүлэг. Цагдаагийн байгууллагын захиргааны хяналтын үйл ажиллагаа;
- Долдугаар бүлэг. Мэдээлэл, тоо бүртгэлийн ажиллагаа;
- Наймдугаар бүлэг. Санхүү, хангамжийн үйл ажиллагаа;
- Есдүгээр бүлэг. Хүний нөөц, алба хаах харилцаа гэсэн бүлгүүдэд заасан журмыг үйл ажиллагаандаа мөрдөж байна.

Дээрх журмыг өмнө хэрэгжиж байсан журамтай харьцуулахад хүний эрхийн чиглэлээр онцлох нэмэлт, өөрчлөлт ороогүй байна. ЦЕГ-ын даргын 2015 оны 2-р сарын 13-ны өдрийн Б/99 тоот тушаалаар баталсан Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журмын “Зарим хөтөлбөр, төлөвлөгөө гаргаж хэрэгжүүлэх” код (109)-д Цагдаагийн байгууллагаас хэрэгжүүлэх хөтөлбөрийг заасан байна. Үүнд, Терроризмоос сэргийлэх төлөвлөгөө, Гамшгаас хамгаалах төлөвлөгөө, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны төлөвлөгөө, Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх, Хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх гэсэн хөтөлбөрийг хэрэгжүүлэхээр заажээ. ЦЕГ-ын 2015 оны тайлан мэдээнд хүний эрхтэй холбоотой хэрэгжүүлсэн үйл ажиллагааны тухай “Нутгийн өөрөө удирдах байгууллага, засаг захиргааны нэгжид гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр 1473, эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн хараа хяналтгүй болсон хүүхдийн асуудлыг шийдвэрлэх чиглэлээр 279, гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх чиглэлээр 1006, бусад 622 нийт 3380 санал хүргүүлж шийдвэрлүүлсэн” хэмээн тусгажээ.

Мөн ХЭҮК-ын даргын баталсан “Цагдаагийн байгууллагын албан хаагчдын хөдөлмөрлөх эрхийн хүрээнд хийх хяналт шалгалтын удирдамж”-ын дагуу хяналт шалгалтын ажлыг зохион байгуулжээ. ХЗЯ, ХЭҮК, ХСИС-тай хамтран Улаанбаатар хотын цагдаагийн газар, түүний харьяа дүүргүүд дэх цагдаагийн хэлтсийн ажилтнуудад чиглэсэн “Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх чадамжийг дээшлүүлэх” сэдэвт сургалт зохион байгуулж нийт 150 гаруй алба хаагчдыг хамруулсан байна.¹⁵ Дээр

¹⁵ ЦЕГ-ын 2015 оны тайлан.

дурдсан Хүний эрхтэй холбоотой хөтөлбөрийн дагуу зохион байгуулсан ажил арга хэмжээний тайлангаас үзэхэд хүний эрхтэй холбоотой ажил арга хэмжээ зохион байгуулсан боловч хэт ерөнхий, гэр бүлийн хүчирхийллийн хэмжээнд нэг талаас авч үзэж ажил зохион байгуулсан нь учир дутагдалтай.

Харин Цагдаагийн алба хаагчдын хөдөлмөрлөх эрхийн асуудлаар ХЭҮК-той хамтран нийтийн хэв журам хамгаалах, хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах чиг үүрэг бүхий алба хаагчидтай уулзалт, фокус ярилцлага, санал асуулга авах ажлыг зохион байгуулсан боловч энэхүү ажил арга хэмжээг алба хаагчийн ажил дүгнэх үзүүлэлттэй холбож авч үзэлгүй орхигдуулжээ. Тэрчлэн, түүний мөрөөр алба хаагчдын ажил дүгнэх шалгуур үзүүлэлттэй холбоотой ямар нэгэн эерэг үр дүнд хүрэх ажил арга хэмжээг зохион байгуулаагүй байна.

Цагдаагийн байгууллагын удирдлага, зохион байгуулалт гэсэн нэгдүгээр бүлэгт ЦЕГ-ын даргын 2015 оны А/25 тушаалаар батлагдсан Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам “Алба хаагчийн ажлыг үнэлэх” код (111)-д Цагдаагийн алба хаагчдын ажлын байрны тодорхойлолт нь тухайн албан тушаалд ажиллаж байгаа албан хаагчийн ажлын үр дүнг үнэлэх гол шалгуур, үзүүлэлт болгон алба хаагчийн үйл ажиллагааны үр дүнг сар, улирал, бүтэн жилээр тооцон дүгнэж, үнэлнэ гэж заажээ. Журмын агуулгыг бүлэглэвэл, алба хаагчийн үйл ажиллагааг үнэлэх, алба хаагчийн жилийн ажлын үр дүнгийн үнэлгээ, түүний дагуу авч хэрэгжүүлэх арга хэмжээ, үнэлгээний төрөл, үнэлгээний баталгаажуулалт гэсэн хэсгээс бүрдэнэ. Нийтийн хэв журам сахиулах, гэмт хэрэгтэй тэмцэх, олон нийтийн аюулгүй байдлыг хангах үндсэн чиг үүргийг нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллага, алба хаагчид хэрхэн биелүүлж байгааг үнэлэх арга үзүүлэлтийг тусгаж, алба тус бүрээр дүгнэх маягтын загварыг баталжээ. Тухайлбал иргэд, байгууллагаас ирүүлсэн гэмт хэргийн талаарх гомдол, мэдээллийг шалгаж шийдвэрлэсэн байдал, хэлтэс, тасгийн дарга болон мөрдөгч нар бүртгэл судалгааг бүрэн хөтөлж байгаа байдал, хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах үйл ажиллагаанд тасгийн даргаас тавьж буй хяналт, гэр бүлийн хүчирхийлэл, насанд хүрээгүй хүмүүсээс үйлдсэн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр зохиосон ажил, арга хэмжээ, тэдгээрийн үр дүн гэх мэт үзүүлэлтийг багтаасан байна.

Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журмын “Хүний нөөц, алба хаах харилцаа” гэсэн есдүгээр бүлэгт нийт 51 журам батлагдсан бөгөөд уг бүлэгт Албан тушаалд томилох болзол, шаардлага, шалгуур, Цагдаагийн байгууллагад анх орох иргэнээс мэргэшлийн шалгалт авах, Туршилтын хугацаагаар ажиллуулах, Цагдаагийн албан тушаалын цол олгох, бууруулах, хураах, Цагдаагийн тангараг өргөх ёслол, Алба хаагчийг сэлгэн ажиллуулах, Алба хаахтай холбоотой маргааныг хүлээн авч хянан шийдвэрлэх, Дүрэмт хувцас өмсөж хэрэглэх, Албан газар, албаны тээврийн хэрэгсэл дотор тамхи татахыг хориглох, Ажлын бус цагаар өөр ажил эрхлэх, Алба хаагчид тэтгэмж олгох, Соёл, соён гэгээрүүлэх ажил, Цагдаагийн мэргэжлийн сургуулийн сонсогчийн дадлагын сургалт, Алба хаагчийн үргэлжилсэн сургалт зохион байгуулах зэрэг журмууд багтсан.

Тус бүлэгт цагдаагийн алба хаагчийн илүү цагаар ажилласан хугацааг тооцож, нөхөн амраах тухай журам нэмж оруулан баталсан байна. ЦЕГ-ын даргын 2015 оны А/79 дугаар тушаалаар Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам “Илүү цагаар ажилласан хугацааг тооцох” код 927-г баталж, байгууллагын удирдлага нь нийтээр амрах баярын болон долоо хоногийн амралтын өдрүүд, ээлжийн ажлаас бусад тохиолдолд шөнийн цагаар ажиллуулсан бол нөхөн амралт эдлүүлэхээр заажээ. Тус журамд зааснаар долоо хоногийн амралтын өдрүүдэд ажилласан бол ажилласан өдрийн хоногоор, нийтээр амрах баярын өдөр болон шөнийн цагаар ажиллуулсан тохиолдолд дараагийн өдрүүдэд, нөхөн амралт эдлүүлээгүй бол алба хаагчтай тохиролцон тохиромжтой үед нь амраах, эсхүл Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журмын 939-д заасны дагуу сувилал, эрүүл мэндийг нөхөн сэргээх амралтад амраахаар зохицуулсан байна. Өндөржүүлсэн зэрэгт ажилласан хугацааг илүү цагаар үүрэг гүйцэтгэсэнд тооцохгүй, алба хаагчийг ээлж дараалан ажиллуулахгүй¹⁶ гэсэн зохицуулалтыг уг журмаар тогтоож өгсөн боловч илүү цагаар ажилласан алба хаагчийн ажлыг дүгнэхдээ бусдаас илүү үнэлэх, ажил дүгнэх үзүүлэлтийн нэг шалгуур болгон оруулах талаар зохицуулалт тусгаагүй учир дутагдалтай байна.

Харин илүү цагаар үүрэг гүйцэтгэсэн алба хаагчид тухайн цагдаагийн байгууллагын удирдлага ажлын үр дүн, өөрийн байгууллагын цалингийн

¹⁶ Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам код (927)

санг харгалзан уламшуулал олгож болохоор заасан нь ажил дүгнэх үзүүлэлтэд алба хаагчдын илүү цагаар үүрэг гүйцэтгэсэн эсэхийг нэмж тусгах шаадлагатай байгааг харуулж байна.

2.2. Цагдаагийн алба хаагчдын ажил дүгнэх үзүүлэлтийн дүн шинжилгээ

Төслийн баг судалгааны ажлын хүрээнд өдөр тутам иргэд, үйлчлүүлэгчидтэй байнга харьцдаг буюу гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах албаны эргүүлийн цагдаа, эргүүлийн офицер, цагдаа жолооч, зохицуулагч цагдаа, хэсгийн байцаагч, мөрдөгч нарын ажил дүгнэх үзүүлэлтэд дүн шинжилгээ хийлээ. Мөн цагдаагийн байгууллагатай хуулийн дагуу гэрээ байгуулан ажилладаг олон нийтийн цагдаагийн ажил дүгнэх үзүүлэлтийг хамруулсан болно.

2.2.1. Эргүүлийн цагдаагийн ажил дүгнэх үзүүлэлт

Эргүүлийн цагдаагийн ажлыг гэмт хэрэгтэй тэмцэх 5, нийтийн хэв журам сахиулах 6, эрэн сурвалжлах 5, урьдчилан сэргийлэх 1, бусад 7 гэсэн нийт 23 үзүүлэлтээр дүгнэж байна.

Эдгээрээс гэмт хэрэгтэй тэмцэх чиг үүргийн хүрээнд “Хэргийн газрын хамгаалалтад ажилласан”, “Илрүүлсэн хэрэг”, “Таслан зогсоосон хэрэг”, “Гэмт хэрэг, зөрчлийн дуудлага мэдээлэл хүлээн авсан бүрт” гэсэн үзүүлэлтүүд багтжээ. Харин “Гэмт хэргийн талаар бичсэн илтгэх хуудас” үзүүлэлт нь илрүүлсэн хэргийн үзүүлэлттэй давхцаж, шууд 5 оноо нэмэгдэхээр байгаа тул тусад нь үзүүлэлт болгон оруулах эсэхийг эргэж нягтлах нь зүйтэй.

Нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах чиг үүргийн хүрээнд “Архи согтууруулах ундаа хэрэглэсэн иргэнийг 103, ар гэр асран хамгаалагчид нь хүлээлгэн өгсөн бүрт”, “Хураасан хутга, мэс, зодооны хэрэгсэл”, “Саатуулсан хүн”, “Торгосон хүн” (20000 төгрөг тутамд), “Захиргааны зөрчлийг шийдвэрлэсэн байдал”, “Хамгаалалтад ажилласан” гэсэн үзүүлэлтүүд багтжээ. Архи согтууруулах ундаа хэрэглэсэн иргэнд эмнэлгийн тусламж үзүүлэх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчид нь хүлээлгэн өгөх нь тухайн иргэнийг гэмт хэрэг

үйлдэх, гэмт хэрэгт өртөж хохирох явдлаас урьдчилан сэргийлдэг тул хүний эрхийг хангах нэг нөхцөлийг бүрдүүлдэг.

“Хураасан хутга, мэс, зодооны хэрэгсэл”, “Саатуулсан хүн” гэсэн үзүүлэлтүүд нь хүний эрхийг хангах зарчимд төдийлөн нийцэхгүй байна. Учир нь гэмт хэрэг үйлдсэн, зөрчил үйлдсэн хүн бүр хутга, мэс, зодооны хэрэгсэл ашигладаггүй бөгөөд иргэдээс ажил хэрэг, ахуйн зориулалтаар авч яваа хутга, багаж хэрэгслийг үүнд хамаатуулан үзэж хураах явдал олонтаа тохиолддог. “Саатуулсан хүн” гэсэн үзүүлэлт нь алба хаагчдад “би хүн саатуулах эрхтэй бас үүрэгтэй” гэсэн явцуу үзлийг төрүүлэхээс гадна “ажлын үзүүлэлт”-ээ биелүүлэхийн тулд иргэдийн эрхийг зөрчих шалтгаан болох сөрөг талтай. Ийм үзүүлэлт алба хаагчдын ажил дүгнэх шалгуур болох нь гэмт хэрэг, зөрчил үйлдсэн этгээдийг Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 5.1 дүгээр зүйлд заасан эрх хязгаарлах арга хэмжээ авах боломжийг хязгаарлаж болох юм.

Торгосон алба хаагчид (20000 төгрөг тутамд) оноо өгөхөөр заасан бөгөөд судалгааны ажлын хүрээнд анкет асуулга авахад 195 хүн буюу 63 хувь нь зарим тохиолдолд хууль тогтоомж зөрчиж торгодог. Тухайлбал, торгуулийн орлого, норм хэмжээг тогтоон алба хаагчдыг уг норм хэмжээг биелүүлэхийг шаарддаг, зарим тохиолдолд зөрчил үйлдсэн этгээдийн эрхийг зөрчих шаардлага гардаг. Ийм учраас торгуулийн норм хэмжээг тогтоох нь буруу гэж үзсэнтэй бид санал нийлж байна. Торгосон хүн, торгуулийн хэмжээг хатуу тогтоосон нь хүний эрхийг хангах зарчимтай харшилна.

Ажил дүгнэх үзүүлэлтэд “Бичиг баримтыг цаг тухайд хөтөлсөн” бол 0.5 оноогоор дүгнэхээр заасан нь илүүц заалт бөгөөд энэ бол үр дүнг илтгэсэн гэхээс илүү хариуцлага, хандлагын асуудал бөгөөд урамшуулах байдлаар оноо өгч дүгнэх шаардлагагүй. Мөн гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээ зохион байгуулсан тохиолдол бүрт оноо өгөхөөр заасан нь ажлын чанар, үр дүн буурах сөрөг талтайг анхаарах хэрэгтэй.

Эрэн сурвалжилж буй хүн, эд зүйл, галт зэвсэг, мал, тээврийн хэрэгслийг эрэн сурвалжилж олж тогтоосон гэсэн үзүүлэлтүүдийг нэгтгэж нэг үзүүлэлт болгож оруулах нь хүний эрхийн зарчим, бусад улс орны цагдаагийн байгууллага алба хаагчдын ажил дүгнэх үзүүлэлттэй нийцэх юм.

Сахилга хариуцлага алдсан арга хэмжээ тооцсон, үүрэг даалгавар биелүүлээгүй, хууль тогтоомж зөрчсөн тохиолдол бүрт 20 оноо хасна гэж заасан нь учир дутагдалтай. Яагаад гэвэл ажил дүгнэх нийт үзүүлэлтийн 50 хувь нь 1-5 оноогоор дүгнэгдэж байгаа тохиолдолд энэ нь хэт өндөр оноо бөгөөд бусад хийсэн ажлыг үгүйсгэнэ. Түүнчлэн сахилгын шийтгэл хүлээсэн этгээд дахин оноо хасуулж байгаа нь оновчгүй юм.

2.2.2. Эргүүлийн офицерийн ажил дүгнэх үзүүлэлт

Эргүүлийн офицерын ажил дүгнэх үзүүлэлт нь гэмт хэрэгтэй тэмцэх 5, нийтийн хэв журам сахиулах 6, эрэн сурвалжлах 5, урьдчилан сэргийлэх 1, бусад 7 нийт 23 үзүүлэлтээр байна. Эдгээр үзүүлэлт нь эргүүлийн цагдаагийн ажил дүгнэх үзүүлэлттэй адил байна. Тиймээс өмнөх дүгнэлтүүд мөн энд дурдагдана. Нэмж хэлэхэд эргүүлийн цагдаа, офицерийн ажил дүгнэх үзүүлэлтэд “Сургалтад хамрагдсан бүрт” 2 оноо өгөхөөр заасан нь сайшаалтай. Гэвч алба хаагчдыг сургалтад хамрагдах боломжоор хангах явдал учир дутагдалтай байна. Тухайлбал, судалгааны хүрээнд 311 алба хаагчаас анкет асуулга авахад ажлын ачаалал, алба хаагчдын орон тооны дутагдалтай байдлаас шалтгаалан сургалтад хамрагдах боломжгүй гэж 9 хувь буюу 28 алба хаагч хариулсан. Иймд ажил дүгнэх үзүүлэлтэд тусгасан сургалтад хамрагдах боломжийг алба хаагчдад олгох шаардлагатай.

2.2.3. Эргүүлийн цагдаа жолоочийн ажил дүгнэх үзүүлэлт

Эргүүлийн цагдаа жолоочийн ажлыг нийт 26 үзүүлэлтээр дүгнэж байгаа бөгөөд эргүүлийн цагдаа, эргүүлийн офицерийн ажил дүгнэх үзүүлэлттэй адил бөгөөд ажлын онцлогоос хамаарч 3 үзүүлэлт нэмэгджээ. Тодруулбал, эргүүлийн авто машины үйлчилгээг тухай бүр хийсэн бол 2, согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодсон зөрчил илрүүлсэн бол 5 оноо нэмэх, жолоочийн буруутай үйл ажиллагаанаас эвдрэл гэмтэл үүссэн бол 20 оноо хасах гэсэн үзүүлэлтүүд байна. Тээврийн хэрэгслийн бүрэн бүтэн байдал, тос тосолгоо, үйлчилгээг тухай бүр хийх явдал нь албаны бэлэн байдлыг хангаад зогсохгүй, авто машинтай үүрэг гүйцэтгэж буй цагдаагийн алба хаагч, түүгээр үйлчлүүлэгч иргэдийн амь нас, эрүүл мэндийг хамгаалах нөхцөл болно.

Согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодсон зөрчил илрүүлэх үзүүлэлтийн тухайд “жолооч” цагдаагийн ажлын онцлогт уялдуулан оруулсан байх магадлалтай ч тэдний хувьд тэр бүр уг зөрчлийг илрүүлэх боломжгүй. Энэ нь ажлын ачаалал, техник хэрэгсэл, хүн хүчтэй холбоотой. Согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодох нь олон нийтийн аюулгүй байдалд халдаж, нэг үйлдлээр олон хүнд нэгэн зэрэг хор уршиг учруулах эрсдэл өндөр учир энэ заалтыг ажил дүгнэх үзүүлэлтэд тусгасан нь сайшаалтай боловч практикаас үзэхэд жолооч цагдаа нь согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодсон зөрчлийг илрүүлэх үүргийг гүйцэтгэдэггүй. Харин нийгмийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах үүрэг гүйцэтгэх явцдаа энэхүү зөрчлийг илрүүлэх боломжтой учир "согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодсон зөрчил ирүүлэх” гэсэн үзүүлэлтийг тусгах шаардлагагүй.

Дээр дурдсан эргүүлийн цагдаа, эргүүлийн цагдаа жолооч, эргүүлийн офицерын ажил дүгнэх үзүүлэлт хоорондоо адил байгаа нь эдгээр албан тушаалын ажил дүгнэх үзүүлэлтийг ажлын байрны тодорхойлолтод нийцүүлэн, тэдгээрийн чиг үүрэг, албаны онцлог, албан тушаалын ангилалд тохируулж шинэчлэх шаардлагатайг харуулж байна.

2.2.4. Зохицуулагч цагдаагийн ажил дүгнэх үзүүлэлт

Зохицуулагч цагдаагийн ажлыг сар бүр 4 хэсэгт хуваасан нийт 38 үзүүлэлтээр дүгнэж байгаа бөгөөд үүнд гудамж, зам дээр шалгалт хийж ажилласан 3, хамгаалалт, хөдөлгөөн зохицуулалтын чиглэлээр 6, эрэн сурвалжлах 4, гэмт хэрэгтэй тэмцэх 1, замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль тогтоомж зөрчсөн зөрчлийг хянан шийдвэрлэх чиглэлээр 22, нийтийн хэв журам сахиулах 1, бусад 3 үзүүлэлт багтаж байна. Зохицуулагчийн зам дээр шалгалт хийж ажилласан үзүүлэлтэд нэгдсэн болон хэсэгчилсэн арга хэмжээнд ажилласан, бусад албанаас явуулж буй арга хэмжээнд оролцсон гэсэн үзүүлэлтүүд хамаарах бөгөөд эдгээр үзүүлэлтэд дурдсан ажлын гүйцэтгэлийг тоон нийлбэрээр үнэлдэг ажээ. Зохицуулагч цагдаа нь хуваарьт постод 6 цагийн хугацаатай үүрэг гүйцэтгэсний дараа нэгдсэн болон хэсэгчилсэн арга хэмжээнд оролцдог. Өөрөөр хэлбэл нэг, зорилготой давхардсан арга хэмжээнд оролцож байгаа нь зохиомол ажлын ачаалал бий болгож байна.

Хамгаалалт, хөдөлгөөн зохицуулалтын чиглэлээр ажилласан үзүүлэлтэд хөдөлгөөн зохицуулалтад ажилласан хүн цаг, хамгаалалтад ажилласан хүн цаг, төр засгийн өндөр дээд хэмжээний зочин төлөөлөгчийн хамгаалалтад ажилласан хүн цаг, төрийн тэргүүн нарын хамгаалалт, бусад зочин төлөөлөгчийн хамгаалалт, олон нийтийг хамарсан арга хэмжээнд оролцсон, бусад гэсэн үзүүлэлтүүд багтжээ. Эдгээрийг ийнхүү ялгаж төрөлжүүлсэн атал адил хэмжигдэхүүнээр үнэлж байгаа тул эцсийн дүндээ дээрх үзүүлэлт ялгаагүй болж, ийнхүү ангилсны учир холбогдлыг бууруулж байна. Тиймээс төрийн тэргүүн, дээд хэмжээний зочин төлөөлөгч, бусад зочин төлөөлөгчийн хамгаалалт, бусад олон нийтийн ажил зэрэгт үүрэг гүйцэтгэсэн тохиолдолд ялгамжтай үнэлэх, эсхүл нэгтгэх шаардлагатай. Хамгаалалт хөдөлгөөн зохицуулалтын чиглэлээр гүйцэтгэх дээрх үзүүлэлт нь олон нийтийн аюулгүй байдлыг хангах чиг үүрэгт багтаж байгаа тул хүний эрхийн зарчимд нийцнэ.

Зохицуулагчийн ажил дүгнэх үзүүлэлтэд эрэн сурвалжилж буй хүн, эд зүйл, эрэн сурвалжлахаар зарлагдсан тээврийн хэрэгслийг олж тогтоосон гэсэн үзүүлэлтүүдийг тусгасан нь сайшаалтай. Гэсэн хэдий ч эдгээрийг нэгтгэж нэг үзүүлэлт болгож оруулах нь илүү оновчтой. Эсхүл эрэн сурвалжилж буй хүн, эд зүйл, тээврийн хэрэгслийг эрэн сурвалжлах үзүүлэлтийн аль нь чухал болохыг тодорхойлж, тэдгээрийн үнэлгээний ялгааг тогтоосны дараа тус тусад нь үнэлэх боломжтой. Гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлээр гэмт хэрэг илрүүлсэн гэсэн нэг үзүүлэлт байгаа бөгөөд чухам ямар төрлийн гэмт хэрэг илрүүлсэн эсэхийг ялгаж тогтоох шаардлагатай. Тухайлбал, хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг, хулгайн гэмт хэрэг гэх мэт.

Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль тогтоомж зөрчсөн зөрчлийг хянан шийдвэрлэх бүлэгт газар дээр нь шийдвэрлэсэн зөрчлийн тоо, шилжүүлсэн зөрчлийн тоо, торгууль ногдуулсан хүн, торгуулийн нийт дүн, эрүүлжүүлэх байранд хүргэж өгсөн хүний тоо, хураасан эд зүйл (хутга мэс), гарал үүслийн бичиггүй мал, малын гаралтай түүхий эд, архи, спирт илрүүлсэн үйлдлийн тоо зэрэг багтжээ. Тэрчлэн, хөдөлгөөний аюулгүй байдлын хууль тогтоомж болон жолоодох үедээ согтууруулах ундаа хэрэглэсэн зөрчил, нийт илрүүлсэн согтууруулах ундааны зүйл, тээврийн хэрэгсэл жолоодох эрхтэй этгээд согтуугаар

тээврийн хэрэгсэл жолоодсон зөрчил, жолоодох эрхийн үнэмлэхгүй этгээд тээврийн хэрэгсэл жолоодсон, бүрэн бус тээврийн хэрэгсэл жолоодсон, жолоочийн хариуцлагын даатгал хийгдээгүй, өнгө муу тээврийн хэрэгсэл болон утаа ихтэй тээврийн хэрэгслээр хөдөлгөөнд оролцсон, техникийн гэрчилгээгүй буюу зөвшөөрөлгүй, улсын дугааргүй, оношилгоонд хамрагдаагүй тээврийн хэрэгслээр хөдөлгөөнд оролцсон, камер хяналтын төхөөрөмжөөр зөрчил илрүүлж шийдвэрлэсэн, түр саатуулсан тээврийн хэрэгслийн тоо, бусад гэсэн үзүүлэлтүүд багтжээ.

Дээрх үзүүлэлтүүд нь бүхэлдээ нийтийн хэв журам сахиулах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах чиг үүрэгт хамаарах бөгөөд зарим үзүүлэлт нь хоорондоо адил байгааг нэгтгэх шаардлагатай. Тухайлбал, жолоодох үедээ согтууруулах ундаа хэрэглэсэн зөрчлийг илрүүлсэн, нийт илрүүлсэн согтууруулах ундааны зүйл, тээврийн хэрэгсэл жолоодох эрхтэй этгээд согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодсон зөрчил, жолоодох эрхийн үнэмлэхгүй этгээд тээврийн хэрэгсэл жолоодсон, бүрэн бус тээврийн хэрэгсэл жолоодсон, жолоочийн хариуцлагын даатгал хийгдээгүй, өнгө муу тээврийн хэрэгслээр хөдөлгөөнд оролцсон, утаа ихтэй тээврийн хэрэгслээр хөдөлгөөнд оролцсон, техникийн гэрчилгээгүй буюу зөвшөөрөлгүй, улсын дугааргүй тээврийн хэрэгслээр хөдөлгөөнд оролцсон, оношилгоонд хамрагдаагүй тээврийн хэрэгслээр хөдөлгөөнд оролцсон зөрчлийг илрүүлсэн гэсэн үзүүлэлтүүд нь бүхэлдээ хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль тогтоомж зөрчсөн зөрчилд багтах учир хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль тогтоомж зөрчсөн зөрчил илрүүлсэн гэсэн үзүүлэлтийг хасах нь зүйтэй.

Зохицуулагч цагдаагийн ажил дүгнэх үзүүлэлтэд тусгасан согтууруулах ундаа хэрэглэсэн үедээ тээврийн хэрэгсэл жолоодсон, бүрэн бус тээврийн хэрэгсэл жолоодсон, утаа ихтэй, оношилгоонд хамрагдаагүй тээврийн хэрэгслээр замын хөдөлгөөнд оролцсон, түр саатуулсан тээврийн хэрэгслийн тоо гэсэн үзүүлэлтүүд нь хүний эрх талаас авч үзвэл эрүүл, аюулгүй орчинд амьдрах иргэний эрхийг хангахад чиглэжээ.

2.2.5. Хэсгийн байцаагчийн ажил дүгнэх үзүүлэлт

Хэсгийн байцаагчийн ажлыг сар бүр 6 хэсэгт хуваасан нийт 40 үзүүлэлтээр дүгнэж байгаа бөгөөд үүнд гэмт хэрэгтэй тэмцэх 5, нийтийн

хэв журам сахиулах 17, эрэн сурвалжлах 5, урьдчилан сэргийлэх ажлын чиглэлээр 4, захиргааны хяналтын чиглэлээр 3, бусад 4 үзүүлэлт багтсан байна. Эдгээр үзүүлэлтэд гэмт хэрэгтэй тэмцэх чиг үүргийн хүрээнд илрүүлсэн хэрэгт 20, эрүүгийн хэрэг үүсгэсэн бол 2, үүсгэхээс татгалзсан бол 1 оноо, харьяаллын дагуу шилжүүлсэн бол 1 оноо, гэмт хэргийн талаар илтгэх хуудас бичсэн бол 5, гэмт хэргийн газрыг хамгаалсан бол 1 оноогоор тус тус дүгнэхээр заасан нь цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны зорилго, зорилт, үндсэн чиг үүрэгтэй шууд хамааралтай байна. Дээрх үзүүлэлтүүд нь эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх үйл ажиллагааны үр дүнг харуулах үзүүлэлт мэт боловч алба хаагчийн илрүүлсэн нэг гэмт хэргийн цаана иргэн, хуулийн этгээдэд учирсан хохирлыг нөхөн төлүүлэх, хохирогчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг сэргээн эдлүүлэх, гэмт хэрэг зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээдэд хуулийн дагуу шийтгэл ногдуулах нөхцөлийг бүрдүүлдэг тул хариуцлага гарцаагүй байх, хууль ёсны зарчмыг хэрэгжүүлэх, хүнийг эрхийг хангах нэг үндэс болж өгнө.

Цагдаагийн хэсгийн байцаагч нь өөрийн хариуцсан сум, баг, хорооны нутаг дэвсгэрт үйлдэгдсэн гэмт хэрэг, зөрчлийн талаарх мэдээ, мэдээлэл хүлээн авах, гомдол мэдээлэл шалгах, эргүүл хийх, биечилсэн судалгаа хийх, хяналт тавих, хууль тогтоомж сурталчлах, урьдчилан сэргийлэх ажил явуулах гэх мэт олон чиг үүргийг гүйцэтгэдэг. Үйлдэгдсэн гэмт хэргийг илрүүлэх зорилгоор хэсгийн байцаагч мэдээлэл цуглуулж, түүнийгээ илтгэх хуудсаар удирдах албан тушаалтандаа танилцуулснаар, цагдаагийн төрөл мэргэжлийн албад тухайн гэмт хэргийг илрүүлж, шалгах арга хэмжээг авдаг. Энэ ажлыг “гэмт хэргийн талаар илтгэх хуудас бичих” үзүүлэлтээр дүгнэдэг байна. “Гэмт хэргийн талаар илтгэх хуудас бичих” нь цагдаагийн хэсгийн байцаагчийн ажил дүгнэхэд зайлшгүй байх ёстой үзүүлэлт юм. Харин гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам сахиулах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах чиг үүрэг гүйцэтгэдэггүй бичээч, конторын цагдаа, аж ахуйн албаны алба хаагч нарын ажил дүгнэх үзүүлэлтээс үүнийг хасаж, бусад гэдэг ангилалд оруулбал зохино. Өнөөгийн байдлаар алба хаагч бүр сард 3 удаа илтгэх хуудас бичиж өгнө гэж тоог хатуу тогтоосон нь үр дүнгүй байна. Иймд тоонд анхаарал хандуулах бус, илтгэх хуудасны үнэн бодитой байдалд

анхаарал хандуулах шаардлагатай. Мөн эрэн сурвалжлах чиглэлээр дээр дурдсаны адил 5 үзүүлэлт тусгасныг нэгтгэх нь хүний эрхийн зарчим, бусад улс орны цагдаагийн байгууллага, алба хаагчдын ажил дүгнэх үзүүлэлттэй нийцнэ.

Хэсгийн байцаагчийн ажил дүгнэх үзүүлэлтэд нийтийн хэв журам хамгаалах чиг үүргийн хүрээнд зөрчлийн талаар хүлээн авч шалгасан гомдол, мэдээлэл (шийдвэрлэсэн) 2, хөөн хэлэлцэх хугацаа зогсоосон материалаас шийдвэрлэсэн эсэх 2, захиргааны зөрчлийг материалжуулан шалгасан 2, захиргааны журмаар түр хураагдсан эд зүйлсийг санд шивсэн бүрт 2, 4 хоногт (хугацаа сунгасан) 2, хугацаа хэтэрсэн хасах 5, олон нийтийн цагдаагийн ажилтныг мэргэжлийн удирдлагаар хангаж ажилласан 5, гэр бүлийн хүчирхийллийн дуудлагаар очиж ажилласан тоо 3, хэдэн хүчирхийлэгчийг албадан саатуулсан 3, хохирогчийг хамгаалах байранд хүргэж өгсөн тоо 4, шүүхэд эрх хязгаарлах арга хэмжээ авахуулах хүсэлт гаргасан тоо 4, шүүхээр баривчлуулсан 5, албадан эмчилгээнд хүргүүлсэн, сайн дурын эмчилгээнд хамруулсан 6, торгосон хүн 20000 нэгж тутамд 2, саатуулах байранд хүргэж өгсөн, эргүүл хамгаалалтад ажилласан 1 оноогоор тус тус дүгнэхээр заасан байна.

Цагдаагийн албаны тухай хуулийн 11-р зүйл нийтийн хэв журам хамгаалах гэсэн заалтын 11.1.1 дэх хэсэгт “зөрчлийн талаарх гомдол, мэдээллийг хүлээн авах, бүртгэх, хуулиар харьяалуулсан зөрчлийг шалгаж шийдвэрлэх, байгууллага, алба хаагчийг мэдээллээр хангах” гэж заасан тул дээр дурдсан үзүүлэлтүүд нь нийтийн хэв журам хамгаалах чиг үүрэгт багтаж байна. Гэвч “зөрчлийн талаарх хүлээн авч шалгасан гомдол, мэдээлэл” (шийдвэрлэсэн), “хөөн хэлэлцэх хугацаа зогсоосон”, “захиргааны зөрчлийг материалжуулан шалгасан”, “захиргааны журмаар түр хураагдсан эд зүйлсийг санд шивсэн”, “хугацаа хэтэрсэн” гэсэн үзүүлэлтүүд нь зөрчил шалгах процессын ажиллагааны явц, үр дүнд хамааралтай үзүүлэлт болжээ. Дээрх үзүүлэлтийг өөрчилж хүний эрхийн зарчимд нийцүүлэх үүднээс зөрчлийн улмаас учирсан хохирлыг барагдуулсан байдал, зөрчлийн шалтгаан нөхцөлийг арилгуулах арга хэмжээ авсан байдал, зөрчлийг бууруулах чиглэлээр зохион байгуулсан ажил арга хэмжээ, үр дүн гэх мэтээр шинэчлэн тогтоох шаардлагатай.

Үзүүлэлтэд гэр бүлийн хүчирхийллийн дуудлагаар очиж ажилласан тоо, хэдэн хүчирхийлэгчийг албадан саатуулсан, хохирогчийг хамгаалах байранд хүргэж өгсөн, шүүхэд эрх хязгаарлах арга хэмжээ авахуулах хүсэлт гаргасан гэсэн үзүүлэлтүүд нь гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэрэг, зөрчлийн дуудлага мэдээллийг хуулийн дагуу шалгаж шийдвэрлэх, хүчирхийллийн улмаас хохирсон иргэний эрхийг хамгаалах, хүчирхийллийн нөхцөл байдлын болон аюулын зэргийн үнэлгээг бодитой тогтоох, тусламж үйлчилгээ үзүүлэх, хүчирхийлэл үйлдэгчид хууль тогтоомжид заасан хариуцлага ногдуулахад үр нөлөөтэй шинэлэг үзүүлэлт болсон нь хүний эрхийн зарчимтай нийцэж байна.

Торгосон хүн, торгуулийн дүн гэх үзүүлэлтэд 20000 төгрөг тутамд 2 оноо өгөхөөр заасан бөгөөд энэ нь алба хаагчдад торгуулийн орлого, норм хэмжээг тогтоон, хангаж ажиллахыг шаардах үндэслэл болж байна. Энэ нь зарим тохиолдолд иргэний эрхийг зөрчих, заавал торгуулийн шийтгэл ногдуулах гэж улайрах зэргээр хүний эрхийг зөрчих үндэс болж байгаа тул торгууль ногдуулах үзүүлэлтийг хасах тухай судалгаанд оролцогчдын цөөнгүй хувь нь санал гаргасныг дурдах нь зүйтэй.

Эргүүл хамгаалалтад ажилласан бүрт 1 оноогоор дүгнэхээр заасан нь алба хаагчдыг эргүүлийн үүргийг чанаргүй гүйцэтгэх үндэс болж байна. Учир нь харьцангуй бага үнэлгээгээр дүгнэхээс гадна эргүүлийн үүрэг гүйцэтгэсэн үр дүн, ажилласан цаг зэргийг орхигдуулсан нь алба хаагчдын ажлын чанар буурах үндэс болдог. Улмаар алба хаагч цалин урамшууллаа нэмэгдүүлэх зорилгоор тасралтгүй ажиллах нь илүү цагаар ажиллахад хүргэж байгаа нь хөдөлмөрлөх эрх зөрчигдөхөд хүргэж байна.

Захиргааны хяналтын чиг үүргийг хэрэгжүүлэх хүрээнд хүчирхийлэл үйлдэгчид хяналт тавьсан тоо, бусад байгууллагатай хамтарсан байдал 3, хараа хяналтгүй хүүхдийг асран хамгаалах байгууллагад болон нийгмийн халамжийн үйлчилгээнд хамруулсан байдал 5, хорихоос суллагдсан, хорихоос өөр төрлийн ялаар шийтгэгдсэн этгээдүүдэд тавих хяналт тогтоосон бүрт 1 оноогоор тус тус дүгнэхээр заажээ. Хараа хяналтгүй хүүхдийг асран хамгаалах байгууллагад болон нийгмийн халамжийн үйлчилгээнд хамруулах үзүүлэлт нь хүүхдийн эрхийг хамгаалах үндэс болно. Иймд хэсгийн байцаагчийн ажил дүгнэх үзүүлэлт хүний эрхийн зарчимд нийцэж байна гэж үзэх боломжтой. Харин хорихоос суллагдсан,

хорихоос өөр төрлийн ялаар шийтгэгдсэн этгээдүүдэд хяналт тавьсан, хүчирхийлэл үйлдэгчид хяналт тавьсан тоо зэрэг нь Цагдаагийн албаны тухай хуулийн 13-р зүйлд заасан захиргааны хяналтын чиг үүрэгтэй хамааралтай бөгөөд нэг хэсгийн байцаагч бүрэн хэрэгжүүлэхэд хүндрэлтэй. Тиймээс үзүүлэлтэд дурдсан ажлын үр нөлөөг дээшлүүлэх, хүний эрхийн зарчимд нийцүүлэхийн тулд хяналтын үйл ажиллагааг хэрэгжүүлэхдээ шинжлэх ухааны ололт амжилт, орчин үеийн техник технологи, тухайлбал цахим гав, GPS ашиглах шаардлагатай.

Хэсгийн байцаагчийн ажил дүгнэх үзүүлэлтэд урьдчилан сэргийлэх үүргийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр зохион байгуулсан ажил, иргэн, аж ахуйн нэгж байгууллагатай хамтран ажилласан бүрт 10, мэдэгдэл, зөвлөмж өгч, үр дүнг тооцсон байдал 1, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчилсан бүрт 2 оноо өгч дүгнэхээр заасан нь бүхэлдээ гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлд багтаж байна. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр олон төрлийн ажил зохион байгуулах боломжтой тул дээрх гурван үзүүлэлтээр хязгаарлах нь алба хаагчдын ажлыг бодитой бус дүгнэх, хийсэн ажлыг нь бүрэн хамаарахгүй байх сөрөг үр дагавар үүсгэх учир дээрх үзүүлэлтүүдийг нэгтгэж “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр зохион байгуулсан ажил, түүний үр дүн” гэсэн үзүүлэлт болгон өөрчлөх нь зүйтэй.

Бусад үзүүлэлтэд шинэлэг ажил санаачилж нэвтрүүлсэн бол 25 оноо өгөхөөр заасан нь ач холбогдолтой. Харин сахилга, хариуцлага алдсан бүрт хасах 20 оноогоор дүгнэхийн оронд хууль тогтоомжийн дагуу ажилладаг, хүний эрхийг хүндэтгэж ажиллах чин эрмэлзэлтэй, сахилга ёс зүйн дутагдалгүй ажилласан, харилцааны соёлтой гэсэн үзүүлэлтэд нэмэх оноо өгөхөөр зааж өгөх нь чухал алхам болно.

2.2.6. Мөрдөгчийн ажил дүгнэх үзүүлэлт

Мөрдөгчийн ажлыг сард 4 удаа буюу 7 хоног бүр, нийт 13 үзүүлэлтээр дүгнэж байна. Мөрдөгчийн ажлыг дүгнэх эдгээр үзүүлэлт нь бүхэлдээ гэмт хэрэгтэй тэмцэх чиг үүрэгт хамаарах бөгөөд мөрдөгчийн ажлыг дараах хоёр хэсэгт хуваан дүгнэж байна. Үүнд:

1. Өргөдөл

- Хэрэг бүртгэлтийн дугаар авсан;
- Мөрдөн байцаалтын дугаар авсан;
- Хэрэг нээхээс татгалзсан;
- Харьяаллын дагуу шилжүүлсэн.

2. Хэрэг

- Яллах дүгнэлттэй шилжүүлсэн;
- Хэрэгсэхгүй болгосон;
- Нэгтгэсэн;
- Харьяаллын дагуу шилжүүлсэн;
- Түдгэлзүүлсэн;
- Хугацаа хэтэрсэн;
- 5-аас 10 дугаар хугацаа сунгасан;
- 10 дугаар хугацаанаас дээш сунгасан;
- Цагдан хорьсон хүн зэрэг болно.

Дээр дурдсан мөрдөгчийн ажлыг дүгнэх үзүүлэлтүүд нь хүний эрхийн зарчмыг хангах гэхээс илүү эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх үйл ажиллагааны үр дүнг харуулах үзүүлэлт гэж харагдахаар байна. Энэ нь мөрдөгчийн ажил үүрэгтэй холбоотойгоор тайлбарлагдана. Мөрдөгчийн ажил дүгнэх үзүүлэлтэд гэмт хэрэг илрүүлэлтийн хувь, ёс зүйн зөрчил, хохирогч, яллагдагчийн эрхийг хангах арга хэмжээ авсан байдал, эрэн сурвалжлагдаж буй хүн, эд зүйл, мал амьтан олж тогтоосон, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр явуулсан ажил, түүний үр дүн, илүү цагаар ажилласан байдал гэсэн үзүүлэлтүүдийг нэмж тусган хүний эрхийн зарчимд нийцүүлэх шаардлагатай. Түүнчлэн дээр дурьдсан алба хаагчдын ажил дүгнэх шалгуур үзүүлэлтийг оноогоор дүгнэх нь оновчтой эсэхийг эргэн харж, үр дүнгээр үнэлэх, алба хаагчдын ажил дүгнэх үзүүлэлтэд тусгасан үйл ажиллагаа бүхэн хүний эрхийг хангахад чиглэгдсэн байхад анхаарал хандуулах шаардлагатай.

2.2.7. Олон нийтийн цагдаагийн ажилтны ажил дүгнэх үзүүлэлт

Олон нийтийн цагдаагийн ажлыг нийт 11 үзүүлэлтээр дүгнэж байгаа бөгөөд үүнд гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлээр 4, нийтийн хэв журам сахиулах чиглэлээр 2, урьдчилан сэргийлэх чиглэлээр 2, бусад 3 үзүүлэлт

багтаж байна. Олон нийтийн цагдаагийн ажил дүгнэх үзүүлэлтэд “гэмт хэрэг, зөрчлийн газрын ул мөрийг хамгаалсан” тус бүрт 5 оноо, “гэмт хэрэг, зөрчлийн талаар цагдаагийн байгууллагад болон холбогдох байгууллагад танилцуулж, судалгаа бүртгэлд авсан байдал” бүрт 15 оноо өгөхөөр заасан нь гэмт хэрэгтэй тэмцэх, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх цагдаагийн чиг үүрэгт хамаарахаар байна. Гэмт хэрэг, зөрчлийн талаар цагдаагийн байгууллага болон бусад холбогдох байгууллагад шуурхай мэдээлэх нь гэмт хэрэг, зөрчлийг таслан зогсоох, хохирогчийн эрхийг хамгаалах, цагдаагийн байгууллага болон бусад холбогдох байгууллагын ажил үйлчилгээг шуурхай хүргэх замаар хүний эрхийг хангаж байна гэж үзэж болох юм.

Ажил дүгнэх үзүүлэлтэд “Илрүүлсэн, таслан зогсоосон гэмт хэрэг” тус бүрт 10 оноо өгөхөөр заажээ. Гэмт хэргийг түргэн шуурхай илрүүлж, таслан зогсоох, гэмт этгээдийг олж тогтоох нь чухал хэдий ч олон нийтийн цагдаа нь Цагдаагийн албаны тухай хуульд заасны дагуу гэмт хэрэг илрүүлэх, таслан зогсоох шууд үүрэг хүлээдэггүй. Гэмт хэрэг, үйлдэл, гэмт этгээдийн талаар мэдээлэл, эсхүл ул мөр олсон тохиолдлыг гэмт хэрэг илрүүлсэн гэж үзээд энэ үзүүлэлтээр дүгнэж болно. Гэвч хуульд заагаагүй үүргийг ажил дүгнэх үзүүлэлтэд оруулж, агуулгаар дүгнэх нь учир дутагдалтай.

Харин “Гэмт хэрэг, зөрчил үйлдсэн этгээдийг цагдаагийн байгууллагад хүргэж өгсөн байдал” гэсэн үзүүлэлт нь дээрх үзүүлэлттэй шууд холбоотой учир дангаараа нэг үзүүлэлт болохгүй. Гэхдээ шаардлагатай тохиолдолд цагдаагийн бусад алба хаагчдын баривчилсан, саатуулсан этгээдийг цагдаагийн байгууллага болон бусад төрийн байгууллагад хүргэх тохиолдол цөөн бус тохиолддог учир гэмт хэрэг зөрчил үйлдсэн этгээдийг хүргэж өгсөн байдлыг энэхүү үзүүлэлтээс өөр үзүүлэлтээр дүгнэх боломжгүй байж болох талтай.

“Хэсгийн байцаагчтай хамтран аж ахуйн нэгж, байгууллагад мэдэгдэл өгч, түүний мөрөөр зохион байгуулсан ажлын үр дүн”, “Хууль тогтоомж тайлбарлан таниулж, ухуулга сурталчилгаа хийсэн байдал”, “Нийгмийн хэв журам хангах талаар хууль сахиулах байгууллага болон бусад хуулийн этгээдээс зохион байгуулсан ажилд оролцсон байдал” зэрэг үзүүлэлтүүд

нь бүхэлдээ гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлийн ажлыг агуулж байна. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр олон төрлийн ажил зохион байгуулж болох учир дээр дурдсан гурван үзүүлэлтээр хязгаарлах нь буруу бөгөөд алба хаагчдын ажлыг бодитой бус дүгнэх, хийсэн ажлыг нь бүрэн хамрахгүй байх сөрөг үр дагавар үүсгэх учир дээрх үзүүлэлтүүдийг нэгтгэж “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр зохион байгуулсан ажил, түүний үр дүн” гэж өөрчлөх нь зүйтэй.

“Сахилга хариуцлагын байдал” гэсэн үзүүлэлтэд 10 оноо өгөхөөр заасан бөгөөд сахилгын ямар нэгэн зөрчил гаргаагүй ажилласан тохиолдолд оноо өгөхөөр заасан нь дэвшилттэй. Харин ажлын цаг ашиглалт гэсэн үзүүлэлтэд 10 оноо өгөхөөр заасан ч энэ үзүүлэлт нь ажилдаа ирэх, ажлаас буух цагийг баримталсан тохиолдолд оноо авах бөгөөд харин илүү цагаар ажилласан, амралтын өдөр үүрэг гүйцэтгэсэн зэргийг тусгаагүй нь хүний эрхийн зарчимтай үл нийцнэ.

2.3. Ажил дүгнэх үзүүлэлтийн талаарх цагдаагийн алба хаагчдын үнэлгээ, дүгнэлт

Цагдаагийн алба хаагчийн ажил дүгнэх үзүүлэлт хүний эрхийн зарчимд нийцэж байгаа эсэхийг судлах хүрээнд цагдаагийн алба хаагчдаас анкет асуулга, бүлгийн ярилцлага хийх зэрэг аргаар судалгаа авч дүн шинжилгээ хийлээ.

2.3.1. Анкет судалгааны аргын дүн

Судалгааг авахдаа түүврийн арга ашиглан ажлын ачаалал, нутаг дэвсгэрийн онцлог шинжийг харгалзан Баянзүрх дүүргийн Цагдаагийн 1-р хэлтсийн 48, Хан-Уул дүүргийн Цагдаагийн 1-р хэлтсийн 41 болон хөдөө орон нутагт ажиллаж буй 87, бусад дүүргийн 135, нийт 311 алба хаагчдыг тус тус хамрууллаа.

А. Судалгаанд оролцогчдын ерөнхий мэдээлэл


Хүснэгт 1. Судалгаанд оролцогчдын ажиллаж буй цагдаагийн газар, хэлтэс

№	Ажиллаж буй цагдаагийн газар хэлтэс	Тоо
1	Архангай аймгийн Цагдаагийн газар	7
2	Баян-Өлгий аймгийн Цагдаагийн газар	5
3	Булган аймгийн Цагдаагийн газар	3
4	Говь-Алтай аймгийн Цагдаагийн газар	5
5	Говь-Сүмбэр аймгийн Цагдаагийн газар	2
6	Дархан-Уул аймгийн Цагдаагийн газар	5
7	Дорнод аймгийн Цагдаагийн газар	11
8	Дорноговь аймгийн Цагдаагийн газар	5
9	Дундговь аймгийн Цагдаагийн газар	4
10	Завхан аймгийн Цагдаагийн газар	4
11	Орхон аймгийн Цагдаагийн газар	5
12	Өвөрхангай аймгийн Цагдаагийн газар	6
13	Өмнөговь аймгийн Цагдаагийн газар	3
14	Сэлэнгэ аймгийн Цагдаагийн газар	6
15	Төв аймгийн Цагдаагийн газар	2
16	Увс аймгийн Цагдаагийн газар	6
17	Ховд аймгийн Цагдаагийн газар	2
18	Хөвсгөл аймгийн Цагдаагийн газар	5
19	Хэнтий аймгийн Цагдаагийн газар	1
20	Нийслэлийн дүүргүүдийн цагдаагийн газар, хэлтэс	224
Нийт дүн		311

Хүснэгт 2. Судалгаанд оролцогчдын албан тушаалын байдал


№	Албан тушаалын ангилал	Тоо
1	Хорооны цагдаа	7
2	Хэв журмын цагдаа	46
3	Зохицуулагч цагдаа	25
4	Эргүүлийн цагдаа	21
5	Криминалистикийн шинжээч	5
6	Цагдаа жолооч	28
7	Бичиг хэргийн ажилтан	9
8	Холбооны инженер	6
9	Мэдээлэл хүлээн авагч цагдаа	11
10	Эрүүлжүүлэх саатуулах байрны цагдаа	17
11	Төлөвлөлт зохион байгуулалт хариуцсан ахлах байцаагч	3
12	Ня-бо	5
13	Хэсгийн байцаагч, хэсгийн төлөөлөгч	10
14	Сумын цагдаа	20
15	Харуул хамгаалалтын цагдаа	30
16	Эрүүгийн мөрдөгч	32
17	Камерын хяналтын цагдаа	2
18	Ахлах байцаагч	6
19	Тасгийн дарга	2
20	Хэрэг бүртгэгч	10
21	Мөрдөгч, ахлах мөрдөгч	13
22	Жижүүрийн цагдаа	3
Нийт дүн		311

График 1. Алба хаагчдын ажилласан жил
(хүний тоо, хувиар)




Судалгаанд оролцсон алба хаагчдын 145 буюу 47 хувь нь 6-10 жил, 78 буюу 25 хувь нь 1-5 жил, 63 буюу 20 хувь 11-15 жил ажилласан нь албх хаагчид цагдаагийн байгууллагад хэр тогтвор суурьшилтай ажиллаж байгааг илтгэж байна.

График 2. Алба хаагчдын насны байдал



Судалгаанд оролцсон алба хаагчдын 19 буюу 6.1 хувь нь 18-25, 213 буюу 68.4 хувь нь 26-32, 57 буюу 18.3 хувь нь 33-39, 13 буюу 4.1 хувь нь 40-48, 9 буюу 3 хувь 48-52, хувь нь насныхан байв.


График 3. Алба хаагчдын хүйс



Судалгаанд хамрагдсан алба хаагчдын 267 буюу 86 хувь нь эрэгтэй, 44 буюу 14 хувь нь эмэгтэй алба хаагч байна.


Б. Санал асуулгын дүн

График 4. Алба хаагчдын ажлыг дүгнэж буй хугацаа




Судалгаанд хамрагдсан алба хаагчдын 146 буюу 47 хувь нь ажлаа сар тутам дүгнүүлдэг гэж хариулсан бөгөөд алба хаагчдын ажлыг улирал, хагас, бүтэн жилээр дүгнэдэг гэсэн хариулт 4-5 хувийг эзэлж байна. Мөн судалгаанд оролцогчдын 31 хувь дээрх бүх хугацаанд тайлан гаргаж, ажлаа дүгнүүлдэг гэжээ.

График 5. Алба хаагчид үйл ажиллагаагаа тайлагнаж буй хугацаа




Судалгаанд оролцогчдын 177 буюу 57 хувь нь өөрийн ажлаа сар бүр тайлагнаж бичгээр тайлангаа гаргаж өгдөг нь тухайн алба хаагчдын ажлыг сар бүр дүгнэх боломж бүрдэж байгаа бөгөөд сар, улирал, хагас жил, бүтэн жил гэх мэт тогтоосон хугацаанд тайлангаа бичиж өгснөөр, ажлаа дүгнүүлдэг байна. Түүнчлэн тухай бүрт амаар танилцуулдаг гэж 3 хувь нь хариулжээ.

График 6. Алба хаагчид өөрийн хийсэн ажлыг бодитой дүгнүүлдэг эсэх




Судалгаанд оролцогчдын 203 буюу дийлэнх (65) хувь нь одоогийн ажил дүгнэх үзүүлэлтээр гүйцэтгэлийн 40-70 хувийг хамарч байгаа нь алба хаагчдын ажлын гүйцэтгэлийн 30-60 хувийг үнэлж, дүгнэлгүй орхигдуулж байна гэжээ.

График 7. Бодитой дүгнүүлж чаддаггүй шалтгаан




Судалгаанд оролцогчдын 96 буюу 31 хувь нь алба хаагчийн ажлын чанарыг тооцдоггүй гэж хариулсан нь алба хаагчдын ажил дүгнэх үзүүлэлтэд гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам сахиулах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах чиг үүргийг хүрээнд зохион байгуулж буй ажил, арга хэмжээний чанар, үр дүнг үл харгалзан, тоон үзүүлэлтээр дүгнэх хандлага давамгайл байгааг илтгэнэ. Мөн судалгаанд оролцогчдын 18 хувь буюу 55 алба хаагч ажлын байрны тодорхойлолтод заасан чиг үүрэгтэйгээ нийцдэггүй гэж хариулснаас үзэхэд ажил дүгнэх үзүүлэлтийг боловсруулахдаа ажлын байрны тодорхойлолтод заасан чиг үүрэгтэй нь уялдуулдаггүй, ихэнх тохиолдолд тусгасан чиг үүргээс өөр ажил үүрэг гүйцэтгүүлж байгааг илтгэн харуулж байна.

График 8. Ажил дүгнэх үзүүлэлт алба хаагчдын ажил үүргийг бүрэн хамардаг эсэх



Судалгаанд оролцсон нийт 311 алба хаагчаас уг асуултад 288 алба хаагч хариулт өгсөн ба оролцогчдын 145 буюу 50 хувь нь алба хаагчийн ажил дүгнэх үзүүлэлт тухайн алба хаагчийн ажлыг дунд зэрэг хамаардаг гэж үзжээ. Энэ нь алба хаагчдын дүгнэгдэхгүй орхигдоод буй ажлыг нэмж тусгахын сацуу, ажлын байрны тодорхойлолт, чиг үүрэгт нэмэлт, өөрчлөлт оруулж, алба хаагчдын ажлыг бүрэн хамруулах шаардлагатайг харуулж байна. Үүний зэрэгцээ судалгаанд оролцогчдын 7 хувь буюу 22 алба хаагч дундаас бага, 18 хувь буюу 55 алба хаагч бүрэн хамаарч чадахгүй гэж дүгнэсэн нь тэдний ажил дүгнэх үзүүлэлт ажлын байрны тодорхойлолтод туссан үйл ажиллагаатай нийцэхгүй байна гэж үзэх үндэслэлтэй. Мөн удирдах албан тушаалтны зүгээс алба хаагчдын гүйцэтгэх ёстой чиг үүрэгт хяналт тавьж, гүйцэтгэл үр дүнг тооцох, бусад алба хаагчдаас ажлын хариуцлага алдах, ажлаа таслах, хийдүүлэх, өөрийн ажлаа бусдаар гүйцэтгүүлэх зэрэгт хяналт тавьснаар судалгаагаар илэрсэн сөрөг үр дүнг бууруулах боломжтой байж болох юм.

График 9. Алба хаагчдын ажил дүгнэх үзүүлэлтийн талаарх сэтгэгдэл



Судалгаанд оролцсон нийт 311 алба хаагчаас уг асуултад 289 алба хаагч хариулт өгсөн ба судалгаанд оролцогчдын 133 буюу 46 хувь нь ажил дүгнэх үзүүлэлтийг ямар нэг байдлаар өөрчлөх шаардлагатай гэж үзсэнээс үзэхэд алба хаагчдын ажлыг бодитой дүгнэх нь асуудалтай байгааг харуулж байна. Хэдийгээр алба хаагчдын гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтийг яг таг тодорхойлох боломжгүй байж болох ч аль болох оновчтой үнэлэхэд ойртуулах шаардлагатай. Үүний тулд салаа утгагүй байх, гүйцэтгэлийн шууд хамаарал зохистой байх, гүйцэтгэлийг хангалттай үнэлэх үндэслэл бүхий шалгуур тогтоох нь ажил дүгнэх үзүүлэлтийг оновчтой болгох алхам юм.

Ажил дүгнэх үзүүлэлтүүд эрхэлж буй ажил үүргийг бүрэн хамарч чаддаггүй бол ямар ажлыг орхигдуулдаг талаарх нээлттэй асуултад нийт судалгаанд оролцсон 311 алба хаагчаас 44 алба хаагч буюу 14.1 хувь нь дараах байдлаар хариулжээ.

График 10. Олон давтамжтай хариулт



Нээлттэй асуултад хариулсан алба хаагчдын 9 буюу 20.4 хувь нь нийтлэг үүргийн дагуу эргүүлийн үүрэг гүйцэтгэсэн тохиолдолд ажил дүгнэх үзүүлэлтэд оруулж тооцдоггүй. Ялангуяа гэмт хэрэгтэй тэмцэх албаны алба хаагч эргүүлийн үүрэг гүйцэтгэсэн тохиолдлыг үнэлэх шаардлагатай гэж үзжээ. Мөн 8.9 хувь буюу 5 алба хаагч цагдаагийн бусад алба, нэгжээс зохион байгуулсан ажил арга хэмжээнд оролцсон нь ажил дүгнэх үзүүлэлтэд тусгагдахгүй байгаа тухай саналаа бичиж ирүүлжээ. Цагдаагийн газар хэлтсийн бусад нэгжээс зохион байгуулсан нэгдсэн арга хэмжээ, хэсэгчилсэн арга хэмжээний хүрээнд үүрэг гүйцэтгэх нь зарим алба хаагчдын ажил дүгнэх үзүүлэлт, ажлын байрны тодорхойлолтод заасан чиг үүрэг нийцдэггүй гэж тэд үзжээ. Нээлттэй асуултад хариулсан алба хаагчдын 18 хувь буюу 8 алба хаагч ажил дүгнэх үзүүлэлтэд ажлын байрны тодорхойлолтод тусгагдсан ажил орхигдсон, эсвэл ажлын байрны тодорхойлолтод заасан ажил үүрэгт хамааралгүй үүрэг гүйцэтгэж байгаа нь ажлыг дутуу дүгнэх үндэс болж байна гэж үзсэн нь үндэслэлтэй.

Мөн 15.7 хувь буюу 7 алба хаагч ажил дүгнэх үзүүлэлтэд гэмт хэргийг бууруулсан үзүүлэлт огт тусгагдаагүй гэж хариулсан ба хороо хариуцсан цагдаа, хэсгийн байцаагч, хэсгийн төлөөлөгч, эрүүгийн мөрдөгч нарын

хариуцсан нутаг дэвсгэрийнхээ гэмт хэргийн гаралтыг бууруулсан үзүүлэлтийг ажил дүгнэхэд тусгаагүй байгаа тул гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын үр дүнг тусгаж, бууруулсан гэмт хэргийн хувь хэмжээг ажил дүгнэх үзүүлэлтэд оруулах шаардлагатай. Судалгаанд оролцсон алба хаагчдын 10.1 хувь буюу 6 алба хаагч бидний ажлыг хийсэн ажлаар дүгнэдэггүй гэсэн ч хийснээр нь буюу нормчлох боломжгүй тул ажлын үр дүнг харгалзан ажил дүгнэх зарим үзүүлэлт тусгаж болно. Тухайлбал, гэмт хэргийн илрүүлэлт, бууруулсан хувь гэх мэт.


Ажил дүгнэх үзүүлэлт ажил үүргийг бүрэн хамарч чаддаггүй гэж 9 буюу 20.4 хувь нь хариулсан бөгөөд албан тушаал өөрчлөгдсөн, дуудлагад явсан, эрүүлжүүлсэн хүний тоо зэрэг ордоггүй, эргүүл хамгаалалт, илүү цагаар ажилласан эсэхийг үнэлдэггүй, хариуцсан чиглэлд гэмт хэрэг зөрчил гараагүй, хороон дээр илүү цагаар ажилласан үр дүн, харуулын цагдаагийн ажлын үр дүн, гэмт хэрэг дуудлага мэдээлэлд очиж ажилласан нь тусгагдаагүй, ажлын байрны тодорхойлолтод заасан ажлаас илүү их ажил хийдэг, гэнэтийн болон бүтээн байгуулалтын ажлууд хамаардаггүй, зарим нэг хугацаатай бичиг хугацаанд нь өгөөгүй гэдгээр шалтаглан илрүүлсэн гэмт хэрэг болон бусад зүйлийг тооцдоггүй гэх мэт орхигдуулалт байгааг анхаарах шаардлагатай. Эдгээр шалтгаан нөхцөлөөс харахад, ажил дүгнэх үзүүлэлтийг сайжруулах нь зүйтэй.

Мөн дээрх саналаас гадна дор дурдсан саналуудыг бичиж ирүүлжээ. Үүнд, цагдаагийн аль нэг тасагт жолоочоор ажиллахад харьяалал нь төлөвлөлт зохион байгуулалтын тасагт хамаардаггүй байтал өөр алба, тасаг, нэгж дээр ажиллуулдаг, ажил дүгнэх үзүүлэлт, шалгуур тохиромжгүй, албан тушаал тус бүр дээр дүгнэдэггүй, офицер, ахлагч бүрэлдэхүүнээр дүгнэдэг, ажлын байрны тодорхойлолтод заасан үүргийн дагуу дүгнэдэггүй. Тиймээс ажил үүргийг бүрэн хамарч чаддаггүй, үзэмж бус хэрэг бүр өөр онцлогтой, ажил дүн мэдээний үзүүлэлт хэт олон, алба хаагч нар өөр хоорондоо адилхан биш, нутаг дэвсгэрт ажиллаж байгаа тул бүгдийг нэг жишиг шаардлагаар дүгнэж болохгүй. Хөдөлгөөн зохицуулах буюу биет зохицуулалт хийсэн ажил тооцогддоггүй, үндсэн чиг үүргийг хэрэгжүүлэх урьдчилан сэргийлэх ажлыг сайн хийж байхад торгосонгүй гээд торгуулийн үзүүлэлтийн тоогоор дүгнэдэг буруу жишиг тогтсон, хэрэг дээр ямар ажиллагаа хийснийг харгалзан үздэггүй, хэргийн шийдвэрлэлтээр дүгнэдэг, хэрэг илрүүлэх ажиллагаанд хэрхэн оролцсон

хэргийг яаж илрүүлсэн ордоггүй, хамгаалалт бэлэн байдалд ажиллах, тухайн хороо хэсэг, тасаг дээрээ үүрэг гүйцэтгэх хугацаандаа хэрэг зөрчил гаргаагүй тохиолдолд ажил дүгнэх үзүүлэлтэнд оруулдаггүй. Тэрчлэн, дандаа бэлэн байдалд ажилладаг нөхцөлөөс болж ажлын үр дүн буруугаар үнэлэгддэг, хоногийн ажилласан хугацааг тооцож чаддаг, 7 хоногийн 1 өдөр амрах хэрэгтэй, саатуулах байрны цагдаагийн дуудлага мэдээлэл орхигдуулсан, үүрэг гүйцэтгэж байхад дарга ахлах байцаагч нарын гүйлт ажил явуулахад хүндрэлтэй байдаг, ахлах, офицер, ахлагчийн ажил дүгнэх үзүүлэлт ижил байдаг учир бодитой дүгнэгддэггүй гэжээ.


Тайлан тооцооноос гадна өдөр тутмын тодорхойлолт олгох, гүйлгээ хийхэд шаардагдах судалгаа гаргах зэрэг ажлыг тооцдоггүй. Бусдын оронд түр томилогдсон буюу хавсран гүйцэтгэсэн ажил үүрэг нь үндсэн чиг үүрэгт байхгүй учраас орхигдуулдаг, оны эцэст шагнал урамшуулал авахад танил талаараа дүгнэж шагнадаг, ажил дүгнэх үзүүлэлт нь өөрөө тодорхой бус учир ажил дүгнэх явдал эргэлзээтэй, аж ахуйн нэгж шалгасан, хөдөө орон нутагт ажлаар явсан, иргэдтэй уулзсан үзүүлэлт байхгүй, хэв журмын цагдаа нь согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодсон жолоочийг барихад ажилласан үзүүлэлт ордоггүй. Тэрчлэн, мэдээлэл хүлээн авагчийн ажлыг дүгнэх талаар дутагдалтай, хэрхэн дүгнэх нь ойлгомжгүй, олон нийтийн ажил байгууллагаас төлөөлж оролцдог тэмцээн, урлаг соёлын ажлыг үнэлдэггүй, ажлын үзүүлэлтэд тусаагүй гэнэтийн ажлыг дүгнэдэггүй, жилийн эцэст ажлын үр дүнг зөв тооцдоггүй, ажилласан цаг, илүү цаг, амралтын өдрөөр ажилласан, илрүүлсэн хэргийг харгалзан тооцдоггүй хэмээн тус тус хариулжээ.

График 11. Алба хаагчдын хүний эрхийн талаарх ойлголт




Судалгаанд оролцсон нийт 311 алба хаагчаас уг асуултад 301 алба хаагч хариулт өгсөн ба судалгаанд оролцогчдын 133 буюу 44.1 хувь нь хүний эрхийн талаарх ойлголт дутмаг, 31 буюу 10.2 хувь нь хангалтгүй хэмээн хариулснаас үзэхэд ажил дүгнэх үзүүлэлтэд хүний эрхийг хангах зарчим, шалгуур үзүүлэлт хомс тусгагдсан болохыг илтгэж байна.

График 12. Ажил дүгнэх үзүүлэлтийг хүний эрхийн зарчимд нийцүүлэх шаардлагатай эсэх



Судалгаанд оролцсон нийт 311 алба хаагчаас уг асуултад 300 алба хаагч хариулт өгсөн ба судалгаанд оролцогчдын 267 буюу 89 хувь нь ажил дүгнэх үзүүлэлтийг хүний эрхийн зарчимд нийцүүлэх шаардлагатай, 33 буюу 11 хувь нь ажил дүгнэх үзүүлэлтийг хүний эрхийн зарчимд нийцүүлэх шаардлагагүй гэж үзсэн нь дээр дурдсан хүний эрхийн талаарх ойлголт хангалттай бус байгааг батлан харуулж байна. Иймд ажил дүгнэх үзүүлэлтэд хүний эрхийн зарчмыг тусгаж өгөх зайлшгүй шаардлагатай гэж судалгаанд оролцогчид үзсэн нь үндэслэлтэй байна.

График 13. Цагдаагийн алба хаагчдын ажил дүгнэх үзүүлэлт хүний эрхийн зарчимтай нийцдэг эсэх



Судалгаанд оролцсон нийт 311 алба хаагчаас уг асуултад 285 нь хариулт өгсөн ба судалгаанд оролцогчдын 103 буюу 36 хувь нь хүний эрхийн зарчимтай нийцдэггүй, 117 буюу 41 хувь нь дунд зэрэг нийцдэг, 18 буюу 6 хувь нь дундаас бага түвшинд нийцдэг хэмээн үзсэн нь ажил дүгнэх үзүүлэлтийг ямар нэг байдлаар хүний эрхийн зарчимд нийцүүлэх шаардлагатай байгааг харуулж байна. Дээрх тоо баримтад үндэслэн алба хаагчдын ажил дүгнэх үзүүлэлт хүний эрхийн зарчимд нийцдэггүй гэсэн дүгнэлтэд хүрч болох юм. Хүний эрхийн ямар зарчимтай зөрчилдөж байна гэсэн асуултад алба хаагчид өөрсдийн эрхийн асуудлыг хөндсөн бөгөөд энэ талаар тайлангийн дараагийн бүлэгт тодорхой авч үзэх болно.

График 14. Ажил дүгнэхдээ баримталдаг зарчим



Алба хаагчдын гүйцэтгэсэн ажлын тоо, чанар нь эцсийн үр дүнд алба хаагчдыг урамшуулах, тэднийг хөгжүүлэхэд чиглэх ёстой гэж судалгаанд оролцогчдын 57 буюу 18 хувь нь алба хаагч үзсэн байна. Тиймээс ажил дүгнэх үзүүлэлт эцсийн үр дүнтэй холбоотой байх, алба хаагчдыг урамшуулах хөгжүүлэхэд чиглэсэн байлгахын тулд чанарын ямар үзүүлэлтийг сонгон авч тусгах, ажлын чанарыг хэрхэн үнэлэх, ажлын эцсийн үр дүнг ямар хэлбэрээр тооцох зэрэг асуудлыг нарийн судалж тогтоох хэрэгтэй юм.

Ажил дүгнэх үзүүлэлт нь байгууллагын дэвшүүлсэн зорилго зорилтыг хангахын тулд ажлын чанар гэдэг ойлголтыг тодруулах шаардлагатай. Ажлын чанар гэдэг нь нийгмийн хөгжил, хүмүүсийн амьдралын

хэрэгцээг тодорхой хэмжээгээр хангах, материаллаг болон оюун санааны баялгийг аль болох бага зардлаар бий болгоход оруулсан бодит хувь нэмэр, түүнд чиглэсэн зорилтот үйл ажиллагааны цогцолбор байдаг тул ажлын чанарыг голлон анхаарах шаардлага тавигдаж байна.

Алба хаагчдын ажлыг үнэлэхдээ ил тод, нээлттэй байх нь ажилтныг бодитой үнэлэх, удирдлагын субъектив хандлага нөлөөлөхөөс урьдчилан сэргийлэх ач холбогдолтой. Нөгөө талаар ажил дүгнэх үзүүлэлтэд тусгавал зохих дээрх зарчмуудыг тусгахгүй байх нь хүний эрхийг зөрчих үндэс болоод зогсохгүй ажил дүгнэхтэй холбоотой сөрөг үр дагавар байнга гарсаар байх болно.

График 15. Ажил дүгнэх үзүүлэлт (Ажил дүгнэх үзүүлэлтэд тусгагдсан шалгуур үзүүлэлт, давхардсан тоогоор)



Алба хаагчдын ажил дүгнэх үзүүлэлт нь алба хаагчдын өөрсдийнх нь эрхийг хангаад зогсохгүй цагдаагийн байгууллага, алба хаагчдын үйл ажиллагаа нь иргэдийн эрхийг хангахад чиглэх ёстой талаар НҮБ-ын Хүний эрхийн дээд комиссарын газрын Хүний эрхийг хангах практик хэмээх бүтээлд “Хүний эрхийг хангах цагдаагийн практик үйл ажиллагаа”, АНУ-ын Кимбала хотын цагдаагийн даргын ажил дүгнэх үзүүлэлт, АНУ-ын Хьюстон хотын цагдаагийн газрын цагдаагийн судалгааны төвийн гаргасан “Орон нутгийн цагдаагийн стратегийг хэрэгжүүлэхэд алба хаагчдын ажлыг дүгнэх үзүүлэлт” хэмээх судалгааны бүтээлүүдэд тодорхой дурдсан байдаг. Баруун европын зарим улс

орон цагдаагийн байгууллагын ажлыг иргэдийн эрхийг хэрхэн хангаж байгаагаар дүгнэж байна.¹⁷

Цагдаагийн алба хаагчдын ажил дүгнэх үзүүлэлтийг хүний эрхийн зарчимд нийцүүлэх шаардлага байна. Хүний эрхийн үзүүлэлтийг ажил дүгнэх үзүүлэлтэд тусгасан байдлыг дэлгэрүүлэн үзвэл НҮБ-ын Хүний эрхийн дээд комиссарын газрын “Хүний эрхийг хангах цагдаагийн практик” хэмээх бүтээлд онц ноцтой гэмт хэргийн бууралт, гэмт хэрэг илрүүлэлтийн түвшин, урьдчилан сэргийлэх арга хэмжээ авсан байдал, үр дүн, хууль сахиулах ажлын бүтээмж, ялгаварлан гадуурхахгүй байх, мөрдөн байцаалтын шударга байдал, гэмт этгээдийг баривчилсан, харилцааны соёл эзэмшсэн, асуудлыг эв зүйгээр шийдвэрлэсэн, биеийн хүч галт зэвсгийг зохистой хэрэглэсэн болон насанд хүрээгүй хүмүүсийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авсан байдал зэргийг хүний эрхийг хангах үйл ажиллагаа мөн гээд эдгээр үзүүлэлтийг ажил дүгнэх үзүүлэлтэд тусгасан байна.

Түүнээс гадна Кимбала хотын цагдаагийн даргын ажил дүгнэх үзүүлэлт, АНУ-ын Хьюстон хотын цагдаагийн газрын Цагдаагийн судалгааны төвийн гаргасан орон нутгийн цагдаагийн стратегийг хэрэгжүүлэхэд алба хаагчдын ажлыг дүгнэх үзүүлэлт хэмээх судалгааны бүтээлүүдэд тус тус бичигдсэн байна. Мөн Филиппиний Үндэсний цагдаагийн байгууллагаас гаргасан гарын авлагын “Хууль сахиулагчдад хэрэгтэй олон улсын хүний эрхийн 10 стандарт” гэсэн хэсэгт дараах үзүүлэлтийг дурджээ. Үүнд:

1. Эрх тэгш хамгаалалт үзүүлэх;
2. Бусдыг хүндэтгэн ажиллах;
3. Хүчийг зохистой хэрэглэх;
4. Тайван жагсаал, цуглааныг зохицуулах;
5. Аминд үл хүрэх зэвсэг, хүч хэрэгсэл ашиглах;
6. Хууль ёсны дагуу гэмт хэрэгтнийг баривчлах;
7. Хоригдогсдын эрхийг хамгаалах;
8. Хоригдогсдод хүнлэг ёсоор хандах;
9. Шударга бус тушаал биелүүлэхээс татгалзах;
10. Хүний эрхийг үл хүндэтгэсэн зөрчлийг мэдүүлэх.

¹⁷ АНУ-ын Хьюстоны Цагдаагийн газрын, цагдаагийн судалгааны хүрээлэн, *Personnel performance evaluations in the community policing context* судалгааны тайлан

Тиймээс дээрх үзүүлэлтийг ашиглан алба хаагчдын ажлын үр дүнг дүгнэх нь хүний эрхийг хангаж буй байдлын илрэл бөгөөд үүнийг санал асуулгаар тодруулсан байдлыг хүснэгтээр харуулъя.

Хүснэгт 3. Цагдаагийн ажил дүгнэх олон улсын жишиг үзүүлэлтийн талаарх оролцогчдын санал бодол


№	Хувилбар	Тоо
1	Гэмт хэргийг бууруулсан хувь	34
2	Гэмт хэрэг илрүүлэлтийн хувь	106
3	Иргэдтэй зөв харилцдаг	46
4	Мөрдөн байцаалтыг шударга гүйцэтгэдэг	8
5	Хуулийн дагуу үйл ажиллагаа явуулдаг	42
6	Тулгарсан асуудлыг эв зүйгээр шийддэг	15
7	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажил явуулсан байдал, түүний үр дүн	38
8	Хохирогчдын эрхийг хангах арга хэмжээ авсан байдал	4
9	Хүний эрхийн зөрчлийг зохих байгууллагад мэдүүлсэн тоо	0
10	Өөрийн санаачилгаар гүйцэтгэсэн ажил	30
11	Объект субъектын судалгаа явуулсан байдал	12
12	Эрэн сурвалжлагдаж буй этгээдийг олж тогтоосон байдал	59
13	Дээрх асуудал бүгд тусгагдаагүй	40
14	Дээрх асуудал бүгд тусгагдсан	42
	Нийт	476

Нийт 12 үзүүлэлтээс давхардсан тоогоор гэмт хэргийн илрүүлэлтийн хувийг ажил дүгнэх үзүүлэлтэд зайлшгүй байх ёстой гэсэн хариултыг сонгосон 106, эрэн сурвалжлагдаж буй этгээдийг олж тогтоосон байдал 59, иргэдтэй зөв харилцдаг 46, хуулийн дагуу ажилладаг 42, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажил явуулсан байдал, түүний үр дүн 38, гэмт хэргийг бууруулсан 34, өөрийн санаачилгаар гүйцэтгэсэн ажил 30 гэж тус тус хариулжээ. Харин мөрдөн байцаалтыг шударга гүйцэтгэдэг, тулгарсан асуудлыг эв зүйгээр шийддэг, хохирогчдын эрхийг хангах арга хэмжээ авсан, объект, субъектийн судалгаа явуулсан байдал гэсэн хариулт 8-15 удаа давтагдсан. Хүний эрхийн зөрчлийг зохих байгууллагад мэдүүлсэн тоо гэсэн үзүүлэлтийг нэг ч алба хаагч сонгоогүй

байна. Эндээс дүгнэхэд алба хаагчдын хүний эрхийн мэдлэг, хандлагын түвшин хангалтгүй байгааг илтгэж байна.

Судалгаанд оролцогчид давхардсан тоогоор дээр дурдсан ажил дүгнэх үзүүлэлтэд туссан гэсэн хариулт 42, тусаагүй гэж 40 хариулт тус тус давтагджээ. Энэ нь цагдаагийн алба хаагчийн ажил үүргээс хамаарч ажил дүгнэх үзүүлэлт ялгаатай байдагтай холбоотой байж болох юм. Тухайлбал, гэмт хэргийг бууруулсан хувийг ажил дүгнэх үзүүлэлтэд тусгах нь зүйтэй байгаа бөгөөд ялангуяа, хөдөө орон нутаг, сумдад ажиллаж байгаа алба хаагчийн ажлыг дүгнэхдээ гэмт хэргийг бууруулсан, гэмт хэргээс урьдчилан сэргийлсэн, таслан зогсоосон хувийг авч үздэггүй зөвхөн шалгасан хэргийн тоон үзүүлэлтийг л авч үздэг байна. Мөн гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам сахиулах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах алба хаагчдаас бусад алба хаагчийн ажил дүгнэх үзүүлэлтэд гэмт хэргийг илрүүлсэн хувь хэмжээ тусгагддаггүй.

График 16. Хууль тогтоомж, дүрэм журмын дагуу гүйцэтгэсэн ажил нь хүний эрхтэй зөрчилддөг эсэх




Судалгаанд оролцсон нийт 311 алба хаагчаас уг асуултад 289 алба хаагч хариулт өгсөн ба хариулт өгсөн оролцогчдын 183 буюу 63.3 хувь нь хууль тогтоомжийн хүрээнд хийсэн ажил зарим тохиолдолд хүний эрхтэй зөрчилддөг, 63 буюу 12.4 хувь нь зөрчилддөг хэмээн хариулжээ. Эрүүгийн, Зөрчлийн, Эрүүгийн хэргийг хянан шийдвэрлэх тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулиуд хоорондоо зөрчилддөг гэж судалгаанд оролцогчид үзжээ. Иймд цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд дагаж мөрдөж буй хууль тогтоомж, дүрэм журмыг хүний эрхийн зарчимд

нийцүүлэх, алдаа хийдэл, давхардлыг арилгах шаардлагатай байна. Зарим шалгуур үзүүлэлтийг өөрчлөх, нэмэх, хасах шаардлагатай эсэхийг лавлахад судалгаанд оролцогчдын 14.7 хувь буюу 46 алба хаагч саналаа бичиж ирүүлсэн байна.

Бүдүүвч 1. Ажил дүгнэх үзүүлэлтийг өөрчлөх санал



График 17. Ажил дүгнэх үзүүлэлтэд нэмэх үзүүлэлт



Судалгаанд оролцсон нийт 311 алба хаагчаас уг асуултад 79 алба хаагч хариулт өгсөн ба хариулт өгсөн оролцогчдын 26 буюу 33 хувь нь илүү цагаар ажилласан байдлыг ажил дүгнэх үзүүлэлтэд тусгах шаардлагатай гэж үзжээ. Мөн илүү цагаар ажилласан ажлын үр дүнг харгалзан нэмэгдэл цалин хөлс олгох талаар зарим алба хаагчид санал бичиж ирүүлсэн байна. Гэвч Цагдаагийн албаны тухай хуулиар илүү цагаар үүрэг гүйцэтгэсэн


тохиолдолд илүү цагийн хөлс урамшуулал олгох талаар ямар нэг заалт байхгүй нь алба хаагчдын эрх зөрчигдөх явдал гарах үндэс болж байгаа бөгөөд нөгөө талаар, алба хаагчдыг илүү цагаар үүрэг гүйцэтгүүлэх явдал түгээмэл болсныг харуулж байна.

Мөн алба хаагчдын 14 буюу 17.7 хувь нь гэмт хэргийн илрүүлэлтийн хувийг ажил дүгнэх үзүүлэлтэд тооцох санал гаргасан бөгөөд энэ нь гэмт хэргийг бууруулах үндсэн зорилтоо алба хаагчид биелүүлэх үндэс болох тул энэ үзүүлэлтийг ажил дүгнэхэд тусгах шаардлагатай. Үүний зэрэгцээ 16 буюу 20.2 хувь нь гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажил явуулсан үзүүлэлтийг ажил дүгнэх үзүүлэлтэд тусгах шаардлагатай гэж үзжээ. Монгол Улсын Засгийн газар, Хууль зүй дотоод хэргийн яамны бодлого үйл ажиллагааг хэрэгжүүлэх, цагдаагийн байгууллагын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын үр нөлөө, арга ажиллагааг сайжруулах эерэг үр дүнд хүрэхэд хувь нэмэр болох боломжтой. Иймд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажил явуулсан байдал гэсэн үзүүлэлтийг нэмж оруулах нь үйлдэгдсэн хэргийг мөрдөхөд гарах зардал, хүн хүчийг хэмнэх боломж бүрдэх юм.

Судалгаанд оролцогчдын 11 буюу 14 хувь нь ажил дүгнэх үзүүлэлтэд сахилга ёс зүйн зөрчил дутагдал гаргаагүй, өөрийн ажлаа хэвийн гүйцэтгэсэн нь ажил дүгнэх үзүүлэлтэд тооцогддоггүй гэж үзсэн ба энэхүү үзүүлэлтийг тусгаж өгснөөр цагдаагийн алба хаагчдыг ёс зүйтэй болгох, алба хаагчийг төлөвшүүлэхэд ач холбогдолтой байж болно.

Санал өгсөн алба хаагчдын 12 буюу 15.1 хувь нь ажил дүгнэх үзүүлэлтэд хүний эрхийг хангасан үзүүлэлтийг нэмж тусгах шаардлагатай гэж үзжээ. Энэхүү үзүүлэлтийг ажил дүгнэхэд тусгаснаар алба хаагчдын эрх, хууль ёсны ашиг сонирхол хангагдаж, улмаар иргэдийн эрх, эрх чөлөөг хангах, шударга ёсыг тогтоох, ялгаварлан гадуурхах, авлига, албан тушаалын гэмт хэрэг буурах гэх мэт олон эерэг үр дүнд хүрэх боломжтой.

Бүдүүвч 2. Ажил дүгнэх үзүүлэлтээс хасах санал



Дээр дурдсан нийтлэг саналаас гадна ажил дүгнэх үзүүлэлтийг өөрчлөх, нэмэгдүүлэх, хасахтай холбоотой дор дурдсан саналуудыг бичжээ. Үүнд, ямар албанд үүрэг гүйцэтгэж байгааг харгалзан Нийтийн хэв журам хамгаалах тасгийн даргын мэдээг товч тодорхой болгох үүднээс хасах, архидан согтуурахтай тэмцэх, тамхины хяналтын тухай хуулийг хэрэгжүүлэх, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр хийсэн гэх мэт ажлыг дүгнэх үзүүлэлтийг хасаж НХЖХТ-ийн дүн мэдээтэй нэгтгэх; амралтгүй ажиллах, эсхүл илүү цагаар ажиллаж байгаа байдлыг хууль биелэгдэх байдлаар оруулж өгөх, тус тусад нь ялгах, алба хаагчийн олон нийтийн ажилд оролцох идэвх санаачилгыг харах, урамшуулах, таслан зогсоосон гэмт хэрэг, зөрчил газар дээр нь засварлуулсан, арилгуулсан зэргийг нэмж оруулах гэжээ.

Урьдчилан сэргийлэх ажлыг хэрхэн хийснийг харгалзаж, торгуулиар шахдаг буруу үзүүлэлтийг хасах, хариуцсан чиглэлд гэмт хэрэг зөрчил гараагүй, сахилга ёс зүйн зөрчилгүй ажилласан бол уг үзүүлэлтийг дүн мэдээнд оруулдаг байх, гудамж, замын уулзвар зохицуулсан ажлыг дүгнэдэггүй, илүү цагаар ажилласан хөлсийг олгохгүй байлаа ч ажлын үзүүлэлтэд нэмэх оноо болгож оруулах, үндсэн ажлын талаар гэдэгт зөвхөн ажлын байрны тодорхойлолтод заагдсан ажлыг ойлгож, түүнийг нь дүгнэх шаардлагатай гэсэн байна. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх

ажлыг дүгнэдэг үзүүлэлттэй болох, удирдлагаас өгсөн үүрэгт ажлын чиглэлийн дагуу хэрэгжүүлсэн ажлыг үнэлж дүгнэх, илүү дэлгэрэнгүй хийсэн үйлдэл бүрийг дүгнэх хэрэгтэй. Шалгасан тоо биш ажлын ачааллыг харгалзсан үзүүлэлт, шийдвэрлэсэн чанарын үзүүлэлтийг тооцох, үндсэн үүргээс гадна ажилласан үүргийн тухай зөрчил илрүүлсэн тохиолдолд ямар зөрчил илрүүлсэн талаар оруулж өгч байх, газар хэлтсээр нь ялгаж дүгнэх хэрэгтэй. Ажилтай нь уялдуулж дүгнэх, алба хаагчдыг ялгаварлахгүй байх хэрэгтэй. Өдрийн 8 цагаас дээш хугацаагаар ажиллавал нэмэлт цагаар тооцох, ажил дүгнэхдээ дүн мэдээг тулгадаг байх, торгуулийн хуудас тасалсан байдлаар дүгнэхийг өөрчлөх, энэ нь алба хаагчид буруу зан төлөвшил тогтоох үндэс болж байна.

Ажилласан өдөр, цагийг бодитой дүгнэх, сард шалгаж буй хэргийнхээ 4-5 хэргийг яллах дүгнэлт үйлдүүлэх саналтай прокурорт явуулах гэдэг дүн мэдээнээс болж хүний эрх зөрчигдөх магадлалтай. Иймээс тухайн алба хаагчдын ажлын байрны тодорхойлолтод заасан үндсэн ажлыг маш үр дүнтэй цөөн шалгуур үзүүлэлтээр дүгнэх, нэмэгдэл болон бусад хийгдсэн ажлын чанар үр дүн, ач холбогдлоор нь дүгнэх, шалгуур үзүүлэлтэд ээдрээ түвэгтэй хэдэн ажил хийснийг үнэлэх, дан ганц гэмт хэрэг илрүүлэх биш байдаг тул ёс зүйн зөрчил гаргадаггүй байх, ажилдаа үнэнчээр ханддаг гэсэн үзүүлэлтийг нэмэгдүүлэх шаардлагатай. Томилолтоор болон жижүүрт гарч ажилласан байдлыг нэмэх оноо болгож дүгнэх, үндсэн ажилд хамаарахгүй бусад ажлын шалгуур үзүүлэлтийг хасах, нэг хүснэгтээр бүх алба хаагч нарын дүн мэдээг дүгнэж байгаа нь буруу тул аймаг, дүүрэг, сум, хороо бүрт өөр өөрөөр тогтоох нь зүйтэй.

Хууль тогтоомж хоорондын зөрчилдөөнтэй холбоотой асуултад 15 алба хаагч хариулсан бөгөөд Эрүүгийн, Зөрчлийн хуулиуд зөрчилдөхөөс гадна бусад хууль тогтоомж зөрчилддөг, Хөдөлмөрийн хууль байнга зөрчигддөг, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам нь Зөрчлийн тухай, Зөрчлийг шалган шийдвэрлэх тухай хуулиудтай, Гүйцэтгэх ажлын тухай хууль нь Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуультай тус тус зөрчилддөг гэж хариулсан атал тодорхой зүйл, заалтад тулгуурлаж тодорхой санал ирүүлээгүй байна. Энэ нь цагдаагийн алба хаагч өөрийн үзэл бодлоо тэр бүр чөлөөтэй илэрхийлж чаддаггүй, ямагт хариуцлага, дарамтаас айдагтай холбоотой байж болох юм.

2.3.2. Нээлттэй хэлэлцүүлгийн дүн

Цагдаагийн алба хаагчдын ажил дүгнэх үзүүлэлт хүний эрхийн зарчимд нийцэж байгаа эсэхийг судлах хүрээнд хэлэлцүүлгийг 2017 оны 11дүгээр сард 4 удаа зохион байгууллаа. Хэлэлцүүлгээс гарсан үр дүнг нэгтгэвэл:

- а. Цагдаагийн алба хаагчдын ажлыг бодитой дүгнэх, хүний эрхийг хангахын тулд эхний ээлжид алба хаагчдын эрхийг хангах ажлыг шат дараатай зохион байгуулах, салбар, байгууллага дотроо хүний эрх зөрчдөггүй байж иргэдийн эрхийг хангаж ажиллах нөхцөл бүрдэнэ. Иймд алба хаагчдын хүний эрхийн талаарх ойлголтыг нэмэгдүүлж, ажил дүгнэх үзүүлэлтийг бодитой болгон нэгжид ажиллаж байгаа алба хаагчийн гүйцэтгэж байгаа ажил үүрэгт нь тохирсон үзүүлэлтээр ажлыг дүгнэх хэрэгтэй.
- б. Цагдаагийн байгууллага, алба хаагчдын ажлыг бодитой бус дүгнэдгээс үүдэн байгууллагаас дэвшүүлсэн зорилго зорилт, чиг үүрэгтэй үл нийцэж, ажлын үр дүн, чанарыг эрхэмлэх бус тооны араас хөөцөлдөж, үр дүнгүй олон ажил зохион байгуулах буруу жишиг тогтоод байна.
- в. Торгуулийн орлого норм гүйцээхэд анхаарах бус гарсан зөрчлийг газар дээр нь засуулах арга хэмжээ авах нь иргэдийн эрүүл аюулгүй орчинд амьдрах эрхийг хангана.
- г. Ажил дүгнэх үзүүлэлт, төрийн алба хаагчийн үр дүнгийн гэрээний биелэлт тооцох ажил хоорондоо уялдахгүй байна. Өөрөөр хэлбэл, сар бүр “В” үнэлгээ авсан алба хаагч үр дүнгийн гэрээгээ дүгнүүлэхэд түүнээс бага дүнгээр үнэлэгдэх, эсхүл илүү үнэлэгдэх явдал гардаг. Сар бүрийн оноог нэмээд онооны дунджаар нь жилийн эцсийн ажлын үнэлгээг гаргах нь бодитой үнэлгээ болно.
- д. Цагдаагийн бүх алба хаагчийн ажил дүгнэх үзүүлэлтийг сайжруулах ажлыг энэхүү судалгааны ажлын хүрээнд хийх боломжгүй, харин тусгавал зохих үзүүлэлтийг боловсруулж санал хүргүүлэх шаардлагатай.
- е. Ажил дүгнэх үзүүлэлт нь байгууллагын нэгжийн төлөвлөгөөг оновчтой төлөвлөөгүйгээс, эсхүл өөр алба хаагч, тухайн тасаг, хэсгийн төлөвлөгөөнд туссан ажлыг гүйцэтгэсний улмаас өөрийн ажлын төлөвлөгөөнд туссан ажлыг хийж гүйцэтгэж чадахгүйд хүрэх тохиодол гарч байгаа нь алба хаагчдын ажлыг дүгнэхэд сөрөг

нөлөө үзүүлж байна.

- ё. Цагдаагийн байгууллага, алба хаагчдын ажлыг дүгнэх гол үзүүлэлт нь хүний эрхийн хууль тогтоомж, олон улсын гэрээ конвенцид заасан эрхийг хангахад чиглэсэн үйл ажиллагаа байх нь зүйтэй.

2.3.3. Фокус бүлгийн ярилцлагын дүн

Судалгааны хүрээнд нийт 78 алба хаагчтай бүлгийн ярилцлага хийж, дүнг нэгтгэлээ. Үүнд:

- а. Ажил дүгнэх үзүүлэлтэд өөрийн ажлаа тааруулахад хүндрэл тулгардаг, өөрөөр хэлбэл гүйцэтгэж буй үүрэгтэй тэр бүр тохирдоггүй.
- б. Мэдээлэл хүлээн авагч, эрүүлжүүлэх, саатуулах байрны цагдаа нар ээлжээс буусан үедээ хэв журмын эргүүлийн үүрэг гүйцэтгэж байгаа нь ажлын хэт их ачаалал үүсгэж, алба хаагчдын эрүүл мэндийн байдал, тэр тусмаа мэдрэлийн ядаргаанаас үүдсэн нойргүйдэл, стресс гэх мэт өвчлөлд өртөх эрсдэлд хүргэж байгаа тул ажлын ачааллыг тэнцүү хуваарилах шаардлагатай.
- в. Цагдаагийн алба хаагчдын амьдралын хүрэлцээтэй түвшинд амьдрах, сурч боловсрох, ээлжийн амралт эдлэх, зав чөлөөтэй байх, эрүүл мэндээ хамгаалуулах эрхийг хангах шаардлагатай.
- г. Гэмт хэрэгтэй тэмцэх албаны алба хаагч ажил үүргийн хуваарийн дагуу гэмт хэрэг илрүүлэх үүрэгтэй атал, мөрдөс зүүсэн бүх алба хаагч сар бүр 2 удаа гэмт хэргийн талаар илтгэх хуудас бичиж өгдөг тогтолцоог өөрчлөх нь оновчтой. Учир нь захиргааны алба хаагчид болох жолооч, бичээч, архивч, бичиг хэргийн ажилтан, нягтлан, нярав гэх зэрэг алба хаагч гэмт хэргийн талаар мэдээлэл цуглуулах боломжгүй байдаг учир сар бүр гэмт хэргийн талаарх илтгэх хуудас бичиж чадахгүйд хүрдэг.
- д. Алба хаагчдын ажлын үзүүлэлтэд тусгасан торгох шийтгэл ногдуулсан байдал гэсэн үзүүлэлтийг хасах нь зүйтэй. Учир нь цагдаагийн алба хаагчид торгуулсан иргэд эргээд цагдаагийн байгууллагад туслах, мэдээ мэдээлэл өгч, хамтран ажиллахгүй байдалд хүрдэг. Нөгөө талаар, цагдаагийн алба хаагчдын итгэл үнэмшил, цагдаагийн байгууллагын нэр хүндэд сөргөөр нөлөөлж байна.

- е. Зарим цагдаагийн алба хаагч тухайлбал, жижүүрийн цагдаа, хэрэг бүртгэгч, мөрдөгч нар эргүүлийн үүрэг гүйцэтгэх, хамгаалалтад ажиллах явдал элбэг тохиолддог. Тиймээс урьдчилан сэргийлэх ажил арга хэмжээ зохион байгуулсан, эргүүлд ажилласан үр дүнг бүх алба хаагчдын ажил дүгнэх үзүүлэлтэд нэмж тусгах нь зүйтэй.
- ё. Хөдөө орон нутагт эргүүлийн цагдаагийн орон тоо байхгүйн улмаас 24 цагийн жижүүрийн үүрэг гүйцэтгээд буусан өдрөө, эргүүлийн үүрэг гүйцэтгэж, шөнийн 1-2 цагт эргүүлээс бууж байна. Илүү цагаар ажилласны улмаас ар гэртээ зориулах, амьдрал ахуйгаа зохицуулах цаг зав гардаггүй. Хөдөө орон нутаг, тэр дундаа сум дундын цагдаагийн тасгуудад бүтэц орон тоо дутуу батлагддаг. Тухайлбал, бичээч, архивч, мэдээлэл судалгаа хариуцсан ажилтан, зөрчлийн тоо бүртгэгч, эргүүлийн цагдаа, цахилгаанчин гэх мэт орон тоо дутуугийн улмаас ажил хавсран гүйцэтгүүлэх зэргээр ачаалалтай ажиллуулдаг ч энэ нь ажил дүгнэх үзүүлэлтэд тусгагддаггүй.
- ж. Алба хаагчдын ажлыг сар бүр дүгнэж байгаа хэдий ч жилийн эцсийн ажил дүгнэхэд сар бүрийн дүнг харгалзаж үздэггүй. Сар бүр “А”, “В” үнэлгээгээр дүгнэгдсэн байхад жилийн эцэст “С” үнэлгээтэй дүгнэгддэг. Иймд сар бүрийн үнэлгээний дунджаар жилийн эцсийн ажлыг дүгнэдэг байх нь зохистой.
- з. Алба хаагчдыг төрөл бүрийн нэгдсэн, хэсэгчилсэн арга хэмжээнд ажиллуулах, тэмцээн уралдаан, урлаг соёлын арга хэмжээнд оролцуулах явдал нь үндсэн ажлаа орхигдуулах шалтгаан болж байна.
- и. Цагдаагийн алба хаагчдын ажлыг ил тод нээлттэй дүгнэх, ажлын үр дүнг харгалзан шагнал урамшуулал олгох явдал харилцан адилгүй байна.

2.4. Цагдаагийн алба хаагчийн хүний эрхийн хэрэгжилт

Цагдаагийн алба хаагчийн ажил дүгнэх үзүүлэлт хүний эрхийн зарчимд нийцэж буй эсэхийг үзэхдээ хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэх, хамгаалах, хангах үүднээс иргэдийн эрх, эрх чөлөөний тухай асуудлыг голлон анхаарч үзсэн ч цагдаагийн алба хаагчийн өөрийнх нь эрх хэрхэн хангагдаж байгааг мөн анхаарч үзэх шаардлагатай байсан тул энэ асуудлыг мөн судалгаанд хамруулан авч үзлээ.

2.4.1. Цагдаагийн алба хаагчийн эрхийг хангах хууль тогтоомж

Цагдаагийн алба хаагчдын эрх, хөдөлмөрлөх эрхийн баталгаа нь Цагдаагийн албаны тухай, Төрийн албаны тухай болон Хөдөлмөрийн хуулиадаар голчлон зохицуулагдана. Тухайлбал, Цагдаагийн албаны тухай хуулийн 3-р зүйлд заасан “Цагдаагийн алба хаагчтай хамаарал бүхий этгээд” гэдгийг “Цагдаагийн алба хаагчийн эхнэр, нөхөр, хамтран амьдрагч, эцэг, эх, өвөг эцэг, эмэг эх, төрсөн болон дагавар, үрчилж авсан хүүхэд, төрсөн ах, эгч, дүү, ач, зээг ойлгоно” хэмээн тайлбарласан ба уг хуулийн 85-р зүйлийн 85.6-д “Албан үүргээ гүйцэтгэхтэй нь холбогдуулан цагдаагийн алба хаагч болон түүний хамаарал бүхий этгээдийн амь нас, эрүүл мэндэд аюул занал учирсан, эсхүл учирч болзошгүй тохиолдолд тэдгээрийн амь нас, аюулгүй байдлыг хамгаалах асуудлыг цагдаагийн байгууллага хариуцна” хэмээсэн нь алба хаагчдын албан үүргээ биелүүлэх хууль зүйн баталгааны хамрах хүрээг өргөтгөсөн, тэдгээрийн гэр бүлийн гишүүдийн эрх, эрх чөлөөг хангах шинэлэг заалт болжээ.

Цагдаагийн албаны тухай хуулийн 66-р зүйлд “Цагдаагийн албанд тавигдах шаардлага”-д цагдаагийн алба хаагчдын боловсролын түвшнийг харгалзан албан тушаалд томилох, дэвшүүлэн томилох талаар заалт бий. Үүнд “Цагдаагийн байгууллага цагдаагийн алба хаагч бүрт мэргэжлээрээ суралцах, албан тушаал дэвших тэгш боломж, нөхцөл бүрдүүлнэ”, “Цагдаагийн албан тушаалд тавигдах тусгайлсан шаардлага, шалгуур үзүүлэлт нь албан тушаалын чиг үүргээ хэрэгжүүлэхэд шаардлагатай боловсрол, мэргэжил, ур чадвар, эрүүл мэнд, бие бялдар, сэтгэл зүйн болон ёс зүйн шаардлага, цагдаагийн албанд болон мэргэжлийн чиглэлээр ажилласан жил зэргээс бүрдэнэ”, “Цагдаагийн байгууллагын тодорхой албан тушаалд анхлан томилох, алба хаагчийг албан тушаал дэвшүүлэн томилохдоо алба хаагчийн мэдлэг, мэргэжил, ур чадвар, гаргасан амжилт, хувийн болон мэргэжлийн ёс зүйг үндэслэл болгож, албан тушаал эрхлэх шат дарааллаар томилох зарчмыг баримтална” гэжээ. Энэ нь сайшаалтай боловч цагдаагийн алба хаагчид хүний нөөц, орон тооны хүрэлцээ, ажлын ачааллаас шалтгаалан тэр бүр боловсролын түвшнээ дээшлүүлэх, магистр, докторын сургалтад хамрагдах боломж хомс, гагцхүү албаны мэргэшүүлэх ба давтан сургалтад хамрагдах боломжтой байдаг нь дээрх заасан хуулийн заалтын шаардлагыг бүрэн хангаж чадахгүй байна.

Мөн Олон улсын эрх зүйн баримт бичиг болон Монгол Улсын Үндсэн хуульд заасан хүний эрхийг хязгаарласан дараах заалтууд байна. Үүнд, Цагдаагийн албаны тухай хуулийн “Алба хаагчийн эрх үүрэг” гэсэн 68-р зүйлийн 68.7-д “Хуульд заасан тохиолдолд удирдах албан тушаалтны зөвшөөрөлгүйгээр хувийн болон албаны ажлаар гадаад улсад зорчихгүй байх үүрэгтэй”, 69.1.8-д “Нам, үйлдвэрчний эвлэлийн гишүүн байх, албаны бие бүрэлдэхүүний дотор аль нэг нам, үйлдвэрчний эвлэлийн үйл ажиллагаа, улс төрийн үзэл баримтлалыг сурталчлах, дэмжлэг үзүүлэх”, 84.5-д “Цагдаагийн алба хаагч албан үүргээ гүйцэтгэх үедээ аливаа улс төрийн нам, түүний үйл ажиллагааны талаар хувийн үзэл бодлоо илэрхийлэх, албаны эрх мэдлээ улс төрийн зорилгоор ашиглахыг хориглоно” гэсэн заалтууд нь Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт, Эдийн засаг нийгэм соёлын эрхийн тухай олон улсын пакт, Монгол Улсын Үндсэн Хуулийн 2-р бүлгийн 16-р зүйлд заасан “чөлөөтэй зорчих”, “эвлэлдэн нэгдэх”, “үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх” эрхийг хязгаарлаж байна.

Цагдаагийн алба хаагчийн үүргээ биелүүлэх баталгааны талаар Олон улсын эрх зүйн баримт бичиг болон Монгол Улсын Үндсэн Хуульд заасан хүний эрхтэй нийцсэн дараах заалтууд хуульчлагджээ. Үүнд, Цагдаагийн албаны тухай хуулийн 86.1-д “Цагдаагийн алба хаагч албан үүргээ гүйцэтгэж яваад гэмт халдлагын улмаас амь насаа алдсан тохиолдолд 10 жилийн үндсэн цалинтай тэнцэх хэмжээний тэтгэмжийг тухайн алба хаагчийн сарын үндсэн цалингийн дунджаар тооцож түүний гэр бүлд нэг удаа олгоно”, 86-р зүйлийн 86.3.1-д “Хөдөлмөрийн чадвар алдалтын хувь хэмжээнээс шалтгаалан хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 30, 60, 90 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний нэг удаагийн нөхөх олговор олгоно”, 86.8-д “Цагдаагийн алба хаагчийг жил бүр эрүүл мэндийн үзлэгт хамруулж, зардлыг улсын төсвөөс санхүүжүүлнэ” гэжээ.

Мөн хуулийн 87 дугаар зүйлд “Эдийн засгийн баталгаа” гэсэн зүйлд “Цагдаагийн алба хаагч ээлжийн амралтаараа өөрийн эсхүл эхнэр, нөхрийн төрсөн нутагт ирэх, очих замын зардлыг тухайн үед мөрдөж байгаа автомашин, төмөр замын үнэлгээгээр тооцож 2 жилд нэг удаа олгоно”, “нийтийг хамарсан эмх замбараагүй байдал, онц байдлын үед болон голомтын бүсэд үүрэг гүйцэтгэсэн цагдаагийн алба хаагчид

албан томилолтын зардлыг ердийн үеийнхээс гурав дахин нэмэгдүүлж олгоно”; “цагдаагийн байгууллага, алба хаагчийг өндөржүүлсэн бэлэн байдал зарласан үед болон ажлын бус цагаар, шөнийн ээлжид, хээрийн сургууль, дадлагын үеэр чиг үүргээ хэрэгжүүлэхэд нь хүнсний болон эдийн хангалтаар хангаж, хоолны зардлыг олгоно” гэсэн зохицуулалтыг тусгажээ.

“Цагдаагийн алба хаагчид олгох хүнсний болон эдийн хангалт, хоолны зардлын хэмжээг цагдаагийн төв байгууллагын дарга тогтооно” гэж заасан нь алба хаагчдын эдийн засгийн баталгааг хангаж өгсөн заалт болжээ. Түүнчлэн Цагдаагийн албаны тухай хуулийн 90-р зүйлийн 90.1-д “Цагдаагийн алба хаагчид жил бүр ажлын 15 өдрийн үндсэн амралт олгож, биеэр эдлүүлнэ”; 90.2-т “Гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах үүрэг бүхий цагдаагийн алба хаагчид алба хаасан 2 жил тутамд ажлын 3 өдрийн, цагдаагийн бусад алба хаагчид алба хаасан 5 жил тутамд ажлын 3 өдрийн нэмэгдэл амралт олгоно”; 90.3-т “Ажлын зайлшгүй шаардлагаар нэмэгдэл амралтаа биеэр бүрэн эдэлж чадаагүй цагдаагийн алба хаагчид түүний зөвшөөрснөөр хоногт ногдох цалинг хоёр дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний мөнгөн урамшил олгоно” гэсэн нь ээлжийн амралтаа биеэр эдэлж чадаагүй алба хаагчийн эрх ашгийг хамгаалсан заалт болсон байна.

2.4.2. Цагдаагийн алба хаагчийн эрхийн хэрэгжилт

Судалгааны явцад хот, хөдөөгийн нийт 311 алба хаагчаас анкетын асуулга авсан бөгөөд энэ хүрээнд хэд хэдэн асуулт нь цагдаагийн алба хаагчийн эрхийн хэрэгжилтийг хөндсөн билээ.

Судалгаанд оролцогчдын 19 хувь буюу 59 алба хаагч үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, үг хэлэх, хэвлэн нийтлэх эрх чөлөө зөрчигдөж байна гэж үзсэн ба энэ нь тэдний санал бодлыг сонсож, эрх ашгийг хамгаалах үйл ажиллагаа хангалттай бус байгаагаас шалтгаалж байж болох юм. Мөн судалгаанд оролцогчдын багагүй хувь эвлэлдэн нэгдэх, үйлдвэрчний эвлэлийн байгууллагын үйл ажиллагаанд оролцох эрх зөрчигдөж байна гэж үзсэн бөгөөд энэ нь шинэчлэн найруулсан Цагдаагийн албаны тухай хуулийн 69-р зүйлийн 69.1.8 дахь хэсэгт заасан “Нам, үйлдвэрчний эвлэлийн гишүүн байх, албаны бие бүрэлдэхүүний дотор аль нэг нам, үйлдвэрчний эвлэлийн үйл ажиллагаа, улс төрийн үзэл

баримтлалыг сурталчлах, дэмжлэг үзүүлэхыг хориглоно”, мөн хуулийн 69.1.10-т “Хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр томилогдсон ажилд очихгүй байх, ажил хаях, албаны хэвийн үйл ажиллагаа алдагдуулахад чиглэсэн бусад арга хэмжээ төлөвлөх, зохион байгуулах, тэдгээрт оролцохыг хориглоно” гэсэн заалт үйлчилдэгтэй холбоотой. Алба хаагчдын ажлын ачаалал, орон тооны дутагдлаас шалтгаалан алба хаагчдын сурч боловсрох эрх зөрчигдсөөр байгаа бөгөөд судалгаанд оролцогчдын 9 хувь буюу 28 алба хаагч энэ эрх зөрчигдөж байна гэж үзжээ.

График 18. Хэрэв нийцдэггүй бол хүний эрхийн ямар зарчим, эрх зөрчигдөж байна вэ?




Нэг цагдаагийн газар, хэлтэст ажиллаж буй алба хаагчдын 60-65 хувийг нийтийн хэв журам сахиулах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах чиг үүрэгтэй эргүүл, харуулын цагдаа, хэсгийн байцаагч, хэсгийн төлөөлөгч, хорооны цагдаа, жолооч цагдаа, машинт эргүүлийн офицер, замын хөдөлгөөн зохицуулагч цагдаа зэрэг албан тушаал эзэлж байгаа бөгөөд дээр дурдсан алба хаагчдын ажлын чиг үүрэг онцлог нь гудамж, талбай, зам харгуй, албаны тээврийн хэрэгсэл дотор албан үүрэг гүйцэтгэдэгээс үүдэн хөдөлмөрийн аятай тухай нөхцлөөр хангуулах эрх зөрчигдөж байна хэмээн хариулах үндэс болсон байх талтай.

Судалгаанд оролцогчдын 7.3 хувь буюу 23 алба хаагч хоол хүнс, амьдралын хүрэлцээтэй түвшинд ажиллаж, амьдрах эрх нь зөрчигдөж

байгаа тухайгаа судалгааны явцад илэрхийлсэн бөгөөд нийт төрийн алба хаагчдын багагүй хувь орон сууц, цалин болон өөр бусад зээлтэй байдгаас амьдралын хүрэлцээтэй түвшинд амьдрах эрх зөрчигдөж байна хэмээн хариулахад хүргэсэн байж болох юм. Нөгөө талаар үнийн өсөлт, эдийн засгийн хямралтай холбогдуулан цалин хөлс, түүнтэй адилтгах орлого өөрчлөгдөхгүй байх нь үүнд нөлөөлсөн байж болох юм. Үүний зэрэгцээ 6 хувь буюу 18 алба хаагч ээлжийн амралт эдлэх эрх зөрчигдөж байна гэж үзсэн бөгөөд энэ нь алба хаагчдыг 1 сараас дээш хугацааны сургалтад хамруулахдаа захиргааны санаачилгаар ээлжийн амралт олгосонд тооцож, тухайн жилдээ ээлжийн амралт эдлэх боломжийг хааж байгаа нь фокус бүлгийн ярилцлагад дурдагдсан байдаг.

Судалгаанд оролцогчдын 12 хувь буюу 37 алба хаагч оршин суух газраа чөлөөтэй сонгох эрх зөрчигдөж байгаа тухай санал асуулгаар илэрхийлсэн бөгөөд энэ нь алба хаагчийг өөр орон нутагт томилох, сэлгэн ажиллуулах, албан тушаал бууруулах, албан тушаал ахиулахдаа тэдний хүсэл зоригийг үл харгалздагтай холбоотой.

График 19. Таны зарим эрхийг хязгаарлах гол хүчин зүйл аль нь вэ?



Судалгаанд оролцогчдын 199 буюу 64 хувь цагдаагийн албаны онцлог, 40 буюу 13 хувь нь байгууллагын эрх ашгийн үүднээс алба хаагчдын эрхийг хязгаарлах, зарим эрх зөрчих явдал байсаар байна. Мөн судалгаанд оролцогчдын 65 буюу 21 хувь удирдах албан тушаалтны шахалт шаардлагаар өөрийн зарим эрхийг хязгаарлаж байна гэж үзжээ. Иймд цагдаагийн байгууллагын албаны онцлог ажлын шаардлагаар алба хаагчдын эрхийг зөрчих, хязгаарлах явдлыг зогсоох нь зүйтэй.

2.4.3. Хөдөлмөрийн хуулийн хэрэгжилтэд хийсэн дүн шинжилгээ

Цагдаагийн алба хаагч нь “Монгол Улсын Төрийн албаны хууль”-д заасанчлан төрийн тусгай албан хаагч тул улс төрийн, төрийн захиргааны, төрийн үйлчилгээний алба хаагчийн нэгэн адил албан тушаалын цалин болон албан ажлын онцгой нөхцөлийн, төрийн алба хаасан хугацааны, зэрэг дэвийн, эрдмийн зэргийн нэмэгдэл зэрэг цалин хөлс авч ажилладаг.

Цагдаагийн алба хаагч нь ардчилсан нийгэмд иргэдийн хуулиар хамгаалагдсан эрх, эрх чөлөөг баталгаатай эдлүүлэхийн тулд Монгол Улсын Үндсэн хууль, түүнд нийцүүлэн гаргасан бусад хууль тогтоомжийг нэг мөр, зөв шударгаар хэрэгжүүлэх хүрээнд хууль тогтоомжийг чанд сахин ажилладаг хэдий ч алба хаагчдын цаг наргүй, амралт чөлөөгүй хүнд хөдөлмөр зохих ёсоор үнэлэгддэггүй, Хөдөлмөрийн хууль хэрэгждэггүй бөгөөд нэгэнт тангараг өргөсөн бол хийх л ёстой хэмээх хатуу шаардлагын дор албан үүргээ гүйцэтгэж байна.

“Нийгмийн харилцааг бүхэлд нь буюу түүний аливаа нэг төрлийг нь зохицуулдаг эрх зүйн хэм хэмжээний нийлбэр цогцыг хууль тогтоомж (*англо-legislaton, opoc- законодательство*) гэх бөгөөд энэхүү ухагдахуунд Үндсэн хууль, хуулиуд, Улсын Их Хурлын тогтоол, Засгийн газрын тогтоол хамаарна”¹⁸ гэж академич С.Нарангэрэл өөрийн бүтээлдээ дурджээ. Төрийн албаны тухай хуульд “Төрийн албан хаагчийн хөдөлмөрийн харилцаатай холбоотой, энэ хуулиар зохицуулаагүй бусад асуудлыг Хөдөлмөрийн хуулиар зохицуулна”¹⁹ гэж заасан бөгөөд дээрх хуулийн заалт болон тодорхойлолтоос харахад цагдаагийн алба хаагчийн хөдөлмөр эрхлэлтийн асуудлыг гагцхүү хуулиар зохицуулахаар байна.

Дарга, захирагчийн өгсөн тушаал шийдвэр хуультай зөрчилдвөл тушаал захирамж биш хуулийн заалтыг баримтлах, хууль нь Үндсэн хуулийн заалттай зөрчилдвөл Үндсэн хуулиа баримтлах нь хууль дээдлэх ёсны гол шалгуур, үзэл баримтлал болдог. Хэн нэгэн дарга захирагчийн өгсөн үүрэг даалгавар, тушаал захирамж нь ерөнхий болон шууд утгаараа хууль зөрчөөгүй байх нь чухал тул тодорхой ажил алба гүйцэтгүүлэхдээ

¹⁸ С.Нарангэрэл. Эрх зүйн эх толь бичиг. УБ. 2007 он. 556 дахь тал

¹⁹ Монгол Улсын Төрийн албаны тухай хууль. 2002 он. 3 дугаар бүлэг. 11 дүгээр зүйлийн 6 дахь хэсэг.

“Хэнийг ч хууль бусаар албадан хөдөлмөрлүүлж болохгүй”²⁰ гэсэн хуулийн заалтыг анхаарч үзэх шаардлагатай.

Цагдаагийн алба хаагчийг хууль болон хөдөлмөрийн гэрээнд заагаагүй нөхцөлөөр илүү цагаар ажиллуулсан тохиолдолд олгох цалин хөлс болон тэдгээртэй холбогдох асуудлыг хөндөж үзэхэд маргаантай зүйл нэлээд байдаг. Өнөөдөр цагдаагийн алба хаагч, тэдний гэр бүлийн гишүүдийн нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд төр, засгаас тусгайлж онцгойлон цогц арга хэмжээ авах төдийлөн шаардлагагүй бөгөөд гагцхүү хүчин төгөлдөр үйлчилж буй Монгол Улсын Хөдөлмөрийн тухай хуулийн холбогдох заалтыг төрийн байгууллагын аль ч шатанд зөв, бүрэн хэрэгжүүлэх ажлыг сайтар зохион байгуулан үр дүнг тооцож ажиллахад л цагдаа хүчтэй, чадвартай болох боломж бага ч гэсэн нэмэгдэнэ. Үүний тулд цагдаагийн байгууллагад ажиллаж байгаа алба хаагчдын албан тушаалын ангилал, зэрэглэлд заасан үндсэн цалинг нэмэгдүүлэх шаардлагатай.

Цагдаагийн алба хаагч гэмт хэрэгтэй тэмцэх, нийгмийн хэв журам сахиулах үйл ажиллагааг хэрэгжүүлэхдээ баяр, амралтын өдрүүдэд илүү цагаар ажиллах шаардлага зайлшгүй тулгардаг. Монгол Улсад албан ёсоор тэмдэглэн өнгөрүүлж бүх нийтээр амардаг баярын өдөр жилд дунджаар 11, амралтын өдөр 7 хоногт 2, сард 8, жилд дундаар 88 удаа тохиодог. Үүнд Хөдөлмөрийн тухай хуулийн 52-р зүйлд “Нийтээр амрах баярын өдөр ажилласан ажилтныг нөхөн амруулаагүй бол дундаж цалин хөлсийг 2 дахин нэмэгдүүлж...”, мөн хуулийн 53-р зүйлд “Илүү цагаар болон долоо хоногийн амралтын өдөр ажилласан ажилтныг нөхөн амруулаагүй бол түүнд 1.5 дахин түүнээс дээш хэмжээгээр нэмэгдүүлсэн цалин олгох”-оор тус тус заасан заалтыг баримтлан хэрэгжүүлэх шаардлагатай.

Хөдөлмөрийн тухай хуулийн холбогдох заалтыг хэрэгжүүлснээр цагдаагийн ахлагчийн цалин сард тодорхой хувиар нэмэгдэж боломжтой. Энэ нь цагдаагийн алба хаагчдад илүү цагаар ажиллах эдийн засгийн сонирхлыг бий болгож, үүнтэй уялдан ажлын үр бүтээл, чанар дээшлэн тэдний ар гэр, ахуй амьдралд жаахан ч гэсэн тус дэм өгөхийг үгүйсгэхгүй. Зах зээлийн харилцааны өнөөгийн нөхцөлд цалин, ахуй хангамж сайн байх тутам мэдлэг боловсролтой чадварлаг боловсон хүчнээр цагдаагийн

²⁰ Монгол Улсын Хөдөлмөрийн тухай хууль. 1999 он. 1 дүгээр бүлэг. 7 дугаар зүйлийн 1 дэх хэсэг.

байгууллагын эгнээ өргөжиж, алба хаагчдын ажлын үр нөлөө, чанар дээшлэхийн зэрэгцээ байгууллагын үйл ажиллагаанд ахиц дэвшил гарах нөхцөл бүрдэнэ.

Аливаа үзэгдэл, үйл явц нь эерэг болон сөрөг талтай байх ба сайн тал нь цагдаагийн алба хаагч илүү цагаар үр бүтээлтэй ажиллан цалингаа нэмэгдүүлэх, нийгмийн асуудлаа тодорхой хэмжээгээр шийдвэрлэх сонирхол байхад, муу тал нь хяналт, тооцоо сулыг далимдуулан бусдын хөдөлмөрийг ашиглах явдал гарч болохыг үгүйсгэх аргагүй.

Судалгааны явцад оролцогчдын 90 гаруй хувь баяр ёслол болон амралтын өдөр ажиллаад үүнийгээ дараа тооцуулдаггүй, эсхүл тооцуулах шаардлагагүй хэмээн хариулжээ.

Хүснэгт 4. Баяр ёслол, амралтын өдрийн ажлыг тооцох байдал

Асуулт	Хариулсан тоо	Хувь
Ажил үүрэг тул баяр ёслол, амралтын өдөр ажиллаад дараа нь тооцуулах шаардлагагүй	210	39.6
Дараа нь нөхөн тооцуулдаг	50	9.4
Огт тооцдоггүй	270	51

Монгол Улсын Хөдөлмөрийн тухай хуулийн “Долоо хоногийн ажлын цаг нь 40 хүртэл байна”²¹, “Ердийн ажлын өдрийн үргэлжлэл 8 хүртэл цаг байна”²², “Ажлын дараалсан 2 өдрийн хоорондох тасралтгүй амралт нь 12 цаг ба түүнээс дээш хугацаатай байна”²³ гэсэн заалтыг мөрдөж ажиллах нь цагдаагийн алба хаагчдын хөдөлмөрийн чадвар алдалтыг багасгах, өндөр бүтээмжтэй ажиллах бололцоо нөхцөлийг бүрдүүлнэ.

Хүснэгт 5. Илүү цагийн хөлс тооцох байдал

Асуулт	Хариулсан тоо	Хувь
Огт тооцдоггүй	438	82.6
Тодорхой хэмжээгээр урамшуулал хэлбэрээр тооцуулдаг	92	17.3
Хөдөлмөрийн тухай хуульд зааснаар тооцож авдаг	0	0

²¹ Монгол Улсын Хөдөлмөрийн тухай хууль. 1999 он. 5 дугаар бүлэг. 70 дугаар зүйлийн 1 дэх хэсэг.

²² Мөн хуулийн 70 дугаар зүйлийн 2 дахь хэсэг

²³ Мөн хуулийн 70 дугаар зүйлийн 3 дахь хэсэг

Цагдаагийн албаны тухай хуулиар гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах үүрэг бүхий алба хаагчийн ээлжийн амралтын нэмэгдэл хоногийг 2 жил тутамд ажлын 3 өдөр, цагдаагийн бусад алба хаагчид алба хаасан 5 жил тутамд ажлын 3 өдрийн нэмэгдэл амралт олгохоор заасан нь алба хаагчдын ажлын нөхцөл, ачаалал, сэтгэл зүйн сөрөг нөлөөллийг бууруулах зорилготой, зөв зүйтэй зохицуулалт болсон. Гэсэн хэдий ч ээлжийн амралтаа бүрэн эдлэх боломж бололцоо байхгүй байгаа нь судалгааны явцад ажиглагдаж байна. Алба хаагчид хуульд заасан ээлжийн амралтаа хууль ёсоор эдэлснээр хөдөлмөрийн чадвараа нөхөн сэргээх, чадвар алдалтыг багасгах, стрессээс гарах, сурч боловсрох, мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх, үр хүүхдийнхээ сурлага, хүмүүжилд болон эрүүл мэнддээ анхаарал хандуулах, эмчлүүлж сувилуулах, ар гэрийнхээ ахуй амьдралд туслах, амьдарч буй орчныхоо ая, тав тухтай байдлыг бий болгох зэргээр нийгмийн асуудлаа шийдвэрлэх нөхцөл боломж бүрдэнэ.

Хүснэгт 6. Цагдаагийн байгууллагын тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжоор олгогдсон ээлжийн амралтаа эдэлдэг байдал

Асуулт	Хариулсан тоо	Хувь
Бүрэн эдэлдэг	56	10.5
Бүрэн эдэлж чаддаггүй	266	50.1
Ажлын шаардлагаар дуудагдаж ажилдаа ордог	138	26
Өөрийн хүсэлтээр амралт дуусахаас өмнө ажилдаа ордог	60	11.3
Дутуу амарсан ч ондоо багтаан гүйцээж амардаг	10	2

Судалгаанд хамрагдсан алба хаагчдын 464 буюу 87.5 хувь нь ээлжийн амралтаа бүрэн эдэлж чаддаггүй нь судалгааны дүнгээс харагдаж байна.²⁴ Цагдаагийн байгууллагын гүйцэтгэх үүрэг, үйл ажиллагааны онцлогоос шалтгаалан офицер бүрэлдэхүүн цагдаа бүрэлдэхүүнээс цөөн хоног амардаг, мөн алба хаагчдын удаан хугацааны амралт нь эдийн засгийн хувьд хүндрэл учруулдаг зэргээс үүдэн өөрсдийн санаачилгаар ажилдаа ордогтой холбоотойгоор ээлжийн амралтаа бүрэн эдэлж чаддаггүй байх

²⁴ Цагдаа судлал сэтгүүл, 2012 оны дугаар №2

талтай. Иймд алба хаагчдын ээлжийн амралтын үргэлжлэх хугацаа, ажлын шаардлагыг харгалзан Хөдөлмөрийн тухай хуулийн 79.4-р зүйлд заасан “ээлжийн амралтыг өөрийн хүсэлтээр тухайн жилдээ хэсэгчлэн эдэлж болно” гэсэн заалтыг удирдлага болгон зохицуулах нь алба хаагчдын хөдөлмөрлөх эрхийг хангахад тус дөхөм болох боломжтой. Мөн түүнчлэн төв орон нутгийн цагдаагийн газар, хэлтсийн эрүүгийн болон хэв журмын нөхцөл байдлыг бодитой үнэлж дүгнэх нь ажлын ачааллыг зөв тооцож, улмаар бүтэц, орон тоог зохицуулахад түлхэц болох ба үүний дүнд нэг алба хаагчид оногдох ачаалал багасаж, хуулиар олгогдсон амрах эрхээ бүрэн дүүрэн эдлэх боломж бүрдэнэ. Энэ бүхний дүнд дараах дүгнэлтэд хүрч байна. Үүнд:

- Монгол Улсын Хөдөлмөрийн тухай хуулийн холбогдох заалтыг хэрэгжүүлж ажилласнаар цагдаагийн алба хаагч, тэдний гэр бүлийн нийгмийн асуудал тодорхой хэмжээгээр шийдэгдэх боломжтой.
- Цагдаагийн алба хаагч нь гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам сахиулах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах чиг үүргийн хүрээнд баяр ёслол, амралтын өдрүүдэд ажилласан тохиолдолд Хөдөлмөрийн тухай хуулийн дагуу нэмэгдэл хөлсийг тооцож олгож байх.
- Ямар ч нөхцөлд цагдаагийн алба хаагчийн ээлжийн амралтыг биечлэн, бүрэн эдлүүлдэг байх боломжийг бүрдүүлэх.
- Цагдаагийн алба хаагчдын эрх зүй, нийгэм, эдийн засгийн баталгааг хүний эрхэд суурилсан зарчмаар бүрэн хангах.

ДҮГНЭЛТ

Цагдаагийн алба хаагчийн ажил дүгнэх үзүүлэлт хүний эрхийн зарчимд нийцэж байгаа эсэхийг судлах явцад нэгдүгээрт, цагдаагийн алба хаагчийн үйл ажиллагаа, гүйцэтгэсэн ажил иргэдийн эрхийг хангаж байна уу; хоёрдугаарт, цагдаагийн алба хаагчийн ажлыг дүгнэхдээ тэдний хувийн эрхийг хангаж байна уу гэсэн 2 асуулт урган гарч байна. Судалгааны явцад дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

1. Цагдаагийн албаны тухай хуульд “Цагдаагийн алба, алба хаагч нь үйл ажиллагаандаа Монгол Улсын Үндсэн хуульд зааснаас гадна хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэх, ил тод, нээлттэй байх”, Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журамд “Цагдаагийн байгууллага, алба хаагчдын ажлыг дүгнэхэд шударга, бодитой байх, ил тод нээлттэй байх, алба хаагчдын эрх үүрэгт нийцсэн байх, хүний эрхийг хангахад чиглэсэн байх, ажлын гүйцэтгэл эцсийн үр дүнтэй уялдаатай байх” зарчмуудыг тусгаж, “Ажлын байрны тодорхойлолт, хүний эрхийн талаарх олон улсын гэрээ, конвенц дотоодын хууль тогтоомжид заасан хүний эрх, эрх чөлөөг хангах нь тухайн албан тушаалд ажиллаж байгаа албан хаагчийн ажлын үр дүнг үнэлэх гол шалгуур, үзүүлэлт болно” гэж заасан нь хүний эрх, эрх чөлөөг хангах, тийнхүү хангасан байх явдал нь алба хаагчийн ажлын үр дүнг дүгнэх гол шалгуур болохыг хуульчлан баталгаажуулжээ.
2. Цагдаагийн албаны тухай хуулийн 68, 69, 84 дүгээр зүйлд: “... зөвшөөрөлгүйгээр хувийн болон албаны ажлаар гадаад улсад зорчихгүй байх, нам, үйлдвэрчний эвлэлийн гишүүн байх, албаны бие бүрэлдэхүүний дотор аль нэг нам, үйлдвэрчний эвлэлийн үйл ажиллагаа, улс төрийн үзэл баримтлалыг сурталчлах, дэмжлэг үзүүлэх” болон “албан үүргээ гүйцэтгэх үедээ аливаа улс төрийн нам, түүний үйл ажиллагааны талаар хувийн үзэл бодлоо илэрхийлэх, албаны эрх мэдлээ улс төрийн зорилгоор ашиглахыг хориглоно” гэж заасан нь Иргэний болон улс төрийн эрхийн

тухай олон улсын пакт, Эдийн засаг, нийгэм соёлын эрхийн тухай олон улсын пакт болон Монгол Улсын Үндсэн хуулийн 16-р зүйлд заасан чөлөөтэй зорчих, эвлэлдэн нэгдэх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийг зөрчиж байна. Үүнийг цагдаагийн албаны онцлогтой холбон тайлбарлаж болно.

3. Цагдаагийн албаны тухай хуулийн “Цагдаагийн алба хаагчийн эрх зүйн байдал” хэмээх 8 дугаар бүлэгт цагдаагийн алба хаагчийн ээлжийн амралт, хууль зүй, эдийн засаг, нийгмийн баталгаа, цагдаагийн алба хаагчийн үйл ажиллагаа, мэргэшлийн түвшний үнэлэх зарчмыг хуульчилсан хэдий ч цагдаагийн алба хаагчийн ажил дүгнэх үзүүлэлтийн талаар тусгайлан зүйл болгож тусгаагүй байна.
4. Судалгаанаас харахад цагдаагийн алба хаагчдын ажил дүгнэх үзүүлэлт ажлын байрны тодорхойлолтод заасан чиг үүрэгт нийцдэггүй, зарим ажил үүргийг орхигдуулсан, зарим шалгуур үзүүлэлт тохиромжгүй, өөр өөр албан тушаалд ажиллаж буй алба хаагчдыг нэг үзүүлэлтээр дүгнэдэг, ажил дүгнэх аргачлал нь хоцрогдсон, алба хаагчдын ажлыг бодитой дүгнэдэггүй, ажлын үр дүнг тооцдоггүй, удирдлагын субъектив хандлага нөлөөлдөг, сарын ажил дүгнэх үзүүлэлт нь жилийн ажлыг дүгнэх үндэс болдоггүй зэрэг зөрчилдөөнтэй цөөнгүй асуудал байна.
5. Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журамд “Цагдаагийн байгууллага, алба хаагчдын үйл ажиллагааны үр дүнг сар, улирлаар дүгнэж, үнэлэх шалгуур үзүүлэлт нь тухайн ажлын байрны тодорхойлолтод заасан чиг үүрэг болон харьяалах дээд шатны байгууллагаас тогтоож өгсөн хүрэх түвшинтэй нийцсэн байна” гэж заасан. Цагдаагийн алба хаагчийн гүйцэтгэх ажил, үүргийг ажлын байр (албан тушаал)-ны тодорхойлолтоор тогтоох бөгөөд уг тодорхойлолтыг цагдаагийн төв байгууллагын дарга баталж, цагдаагийн алба хаагчийн үйл ажиллагаа, мэргэшлийн түвшнийг Төрийн албаны тухай хуульд заасны дагуу үнэлж, дүгнэдэг. Гэтэл үр дүнгийн гэрээний үзүүлэлт, Цагдаагийн алба хаагчийн ажил дүгнэх үзүүлэлтээс зөрүүтэй байгаа нь ажлын үр дүнг үнэлэхэд хүндрэл учруулж байна.

6. Ажил дүгнэх үзүүлэлтэд тухайн албаны чиг үүрэг, ажил, мэргэжлийн онцлогийг тусгасан боловч алба хаагчийн гүйцэтгэх үүргийг нарийвчлан заагаагүй, офицер, ахлагч ялгаагүй ижил үзүүлэлтээр үнэлсэн, зарим үзүүлэлтийг олон ангилалд хуваасан боловч үнэлж дүгнэх аргачлал нь хэт ерөнхий зэрэг анхаарах зүйл байна.
7. “Илүү цагаар ажилласан хугацааг тооцох” журам (код 927)-д “Байгууллагын удирдлага нь алба хаагчийг ... илүү цагаар ажиллуулсан бол нөхөн амралт эдлүүлэх” зохицуулалтыг шинээр оруулжээ. Уг журмаар өндөржүүлсэн зэрэгт ажилласан хугацааг илүү цагаар үүрэг гүйцэтгэсэнд тооцохгүй, алба хаагчийг ээлж дараалан ажиллуулахгүй гэж зохицуулжээ. Гэвч алба хаагчийн ажлыг дүгнэхдээ илүү цагийг тооцох, үнэлэх, ажил дүгнэх үзүүлэлтийн нэг шалгуур болгон оруулах шаардлага үүсэж байна.
8. Эргүүлийн цагдаа, цагдаа жолооч, эргүүлийн офицер, хэсгийн байцаагчийн ажил дүгнэх үзүүлэлтэд “гэмт хэрэг илрүүлсэн” тохиолдолд 20 оноо, “архи согтууруулах ундаа хэрэглэсэн иргэнийг 103, ар гэр, асран хамгаалагчид нь хүлээлгэн өгсөн” тохиолдолд 1 оноо өгөхөөр байгаа нь зөвхөн гэмт хэрэг илрүүлэх, зөрчил шийдвэрлэх асуудалд илүү анхаарал хандуулж, үйлчилгээний шинжтэй үйл ажиллагаанд бага ач холбогдол өгснийг илэрхийлнэ. Гэвч аль аль нь хүний амь нас, эрүүл мэндтэй холбоотой. Мөн саатуулсан хүн, торгуулийн мөнгөний дүн (20000 төгрөг)-гээр алба хаагчдын ажлыг дүгнэх нь иргэдийн эрх, эрх чөлөөнд халдах, зөрчих нэг нөхцөл болж байна.
9. Алба хаагчдын ажил дүгнэх үзүүлэлтэд сахилга хариуцлага алдсан, арга хэмжээ тооцсон, үүрэг даалгавар биелүүлээгүй, хууль тогтоомж зөрчсөн тохиолдол бүрт 20 оноо хасахаар заасан нь сахилгын шийтгэл хүлээсэн алба хаагчийг давхар шийтгэж, хохирох байдалд хүргэхээр байна. Үүний оронд сахилга, ёс зүйн дутагдалгүй ажилласан гэсэн үзүүлэлт нэмж, нэмэх оноо өгөх нь хүний эрх, тэгш байдлыг хангах алхам болно.

10. Хэсгийн байцаагчийн ажил дүгнэх үзүүлэлтэд зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа, мөрдөгчийн ажил дүгнэх үзүүлэлтэд эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны шинжтэй үйл ажиллагааг илүүтэй тусгасан нь ажил үүргийн онцлогтой холбоотой байна. Алба хаагчдын ажил дүгнэх үзүүлэлтэд сургалтад хамрагдсан тохиолдолд оноо өгч дүгнэх тухай оновчтой зүйл байна. Үүний зэрэгцээ мөрдөгчийн ажил дүгнэх үзүүлэлтэд гэмт хэргийг бууруулсан хувь, хохирогчийн эрхийг хангах арга хэмжээ авсан байдал зэрэг үзүүлэлтийг нэмж тусгах, олон нийтийн цагдаагийн ажил дүгнэх үзүүлэлтийг хуулиар хүлээсэн эрх, үүргийн хүрээнд болгох зэрэг өөрчлөлт оруулах хэрэгцээ шаардлагатай.
11. Анкетын асуулгад оролцогчдын 64 хувь буюу дийлэнх алба хаагч одоогийн ажил дүгнэх үзүүлэлт тухайн ажилтны үүрэгт ажлын 40-70 хувийг дүгнэдэг гэж хариулсан нь ажил дүгнэх үзүүлэлт алба хаагчдын хийж гүйцэтгэж байгаа ажлыг бүрэн хамарч чадахгүй, ажлын байрны тодорхойлолт, чиг үүрэгт нь тохирохгүй байгааг харуулж байна.
12. Ажил дүгнэх үзүүлэлт оновчгүй байгаа нь албаны шаардлагаар ажлын байрны тодорхойлолтод тусгагдаагүй ажил, үйлчилгээ явуулах, тасаг нэгжийн төлөвлөгөөг оновчтой төлөвлөөгүйгээс алба хаагч өөрийн ажлаа бүрэн гүйцэтгэж чаддаггүй, өөр алба хаагчийн эсвэл тухайн тасаг хэсгийн төлөвлөгөөнд тусгасан өөрт шууд хамааралгүй ажил үүрэг гүйцэтгэх шалтгаан болсоор байгааг судалгаанд оролцсон алба хаагчид шүүмжилсэн байна.
13. Судалгаанд оролцогчдын 162 буюу 50.5 хувь нь хүний эрхийн талаарх ойлголт дутмаг, хангалтгүй, мэдэхгүй гэж хариулсан бол, ажил дүгнэх үзүүлэлт хүний эрхийн зарчимд огт нийцдэггүй гэж 111 буюу 36 хувь үзсэн. Түүнчлэн судалгаанд оролцсон алба хаагчдын 143 буюу 46 хувь ажил дүгнэх үзүүлэлтийг шинэчлэх, 267 буюу 89 хувь хүний эрхийн зарчимд нийцүүлэх шаардлагатай гэж дүгнэлээ.

14. Цагдаагийн алба хаагчийн зарим эрхийг хязгаарлах нь албаны онцлог гэж судалгаанд оролцогчдын 64 хувь үзсэн бөгөөд хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлсэн үйл ажиллагаа нь хүний эрхтэй зөрчилддөг гэж 63 хувь нь үзжээ. Энэ нь цагдаагийн байгууллагын үйл ажиллагаа алба хаагчийн хувийн эрхийг хязгаарлахын хамт, тэднээс явуулж буй үйл ажиллагаа нь иргэдийн эрхийг хүндэтгэх, хангах зарчимтай зөрчилдөж байдгийг илтгэж байна.
15. Дээр дурдсан асуудлаас улбаалан иргэд, алба хаагчдын эрх, эрх чөлөө баталгаатай хангагдаж чадахгүй байх нөхцөл үүсэж байна. Тиймээс зохион байгуулалтын шинжтэй асуудлыг засаж залруулах нь чухал юм. Үүний тулд алба хаагчдын ажил дүгнэх үзүүлэлтийг боловсронгуй болгон сайжруулах, холбогдох заалтыг Хүний эрхийн түгээмэл тунхаглал, Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ конвенц, Үндсэн Хуульд заасан хүний эрх эрх чөлөөтэй уялдуулах нь зүйтэй.

САНАЛ, ЗӨВЛӨМЖ

1. Ажил дүгнэх үзүүлэлтийг *Internal Police Science Association (IPSA)*, *UN High Commissioners' Office for the Human Rights* зэрэг олон улсын байгууллагаас гаргасан “*World internal security police index*”, “*The assessing the performance index*” зэрэгт нийцүүлэн боловсруулах;
2. Гадаадын зарим орны цагдаагийн байгууллага, алба хаагчдын ажил дүгнэх шалгуур үзүүлэлт тогтоох үе шат, дүрэм журам, журамласан үйл ажиллагаа, хэмжээ хязгаар, арга туршлагыг судалж нэвтрүүлэх замаар өөрийн орны цагдаагийн байгууллага, алба хаагчдын ажил дүгнэх үзүүлэлтийг боловсронгуй болгох;
3. Алба хаагчдын гүйцэтгэсэн ажлын тоо, чанар нь эцсийн үр дүнтэй уялдаж алба хаагчдыг урамшуулах, тэднийг хөгжүүлэхэд чиглэсэн байх зарчмыг Цагдаагийн албаны тухай хууль болон Цагдаагийн байгууллагын үйл ажиллганы журамд тусгах;
4. ЦЕГ-ын даргын тушаалаар батлагдсан алба хаагчдын ажил дүгнэх журам (Код 111)-д дараах нэмэлт, өөрчлөлтийг тусгах нь зүйтэй. Үүнд:
 - а. Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журмын 111.3 дахь хэсэгт заасан нэр томъёоны ойлголт хэсэгт “Ажил дүгнэх үзүүлэлт гэж цагдаагийн алба хаагчдын ажлын эцсийн үр дүнг үнэлэх шалгуурыг хэлнэ” гэж тодорхойлох;
 - б. “Цагдаагийн байгууллага, алба хаагчдын ажлыг дүгнэхэд шударга, бодитой, ил тод, нээлттэй байх, алба хаагчдын эрх үүрэгт нийцсэн байх, хүний эрхийг хангахад чиглэсэн байх, ажлын гүйцэтгэл эцсийн үр дүнтэй уялдаатай байх зарчмыг тус тус баримтална” гэж нэмж тусгах;
 - в. 111.5.1-д “Ажлын байрны тодорхойлолт, хүний эрхийн талаарх олон улсын гэрээ, конвенц, дотоодын хууль тогтоомжид заасан хүний эрх, эрх чөлөөг хангах нь тухайн албан тушаалд ажиллаж байгаа албан хаагчийн ажлын үр дүнг үнэлэх гол шалгуур, үзүүлэлт болно” гэж шинээр заалт оруулах;
 - г. 111.5.2-т “Ажил дүгнэх шалгуур үзүүлэлтэд хүний эрхийн хангах зарчмыг тусгасан байна” гэж нэмэх;

- д. 111.5.4-т “Нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн алба хаагчдын ажил дүгнэх үзүүлэлтийг тухайн орон нутгийн онцлогт тохируулж нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагын дарга, алба хаагчдын эрхлэх ажлын чиг үүрэгт нийцүүлэн, ажил дүгнэх шалгуур үзүүлэлтийг боловсруулж, баталж мөрдүүлнэ” гэж нэмэх.
 - е. 111.5.5-д “Байгууллагын ажил дүгнэх шалгуур үзүүлэлтийг харьяалах дээд шатны байгууллагын дарга баталж мөрдүүлнэ. Цагдаагийн төв байгууллага нь нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллага, алба хаагчдын ажил дүгнэх шалгуур үзүүлэлтийн хүрэх түвшнийг тодорхойлно” гэж өөрчлөх;
 - ё. 111.5.8-д “Шууд харьяалан удирдах дарга нь алба хаагчийн ажлын гүйцэтгэл, үйл ажиллагааны үр дүнг ил тод, нээлттэй, шударгаар, биечлэн дүгнэх” гэж өөрчлөх;
 - ж. 111.5.10-т “Сар бүрийн ажил дүгнэсэн онооны дунджаар дүгнэж, үнэлнэ” гэж нэмэлт оруулах;
 - з. 111.6.6-д “Хяналт шалгалт, үнэлгээ, дотоод аудит хариуцсан нэгж нь алба хаагчдын ажил дүгнэх үзүүлэлтэд дүн шинжилгээ хийж байгууллага алба хаагчдын ажил дүгнэх үзүүлэлт нь ажлын байрны тодорхойлолтод тусгасан чиг үүрэгтэй тохирч байгаа эсэх талаар дүгнэлт гаргаж түүнд нийцүүлэх арга хэмжээ авна” гэж шинээр заалт оруулах.
5. Тус журмаас гадна Цагдаагийн ерөнхий газрын Дотоод хяналт, аюулгүй байдлын албанаас цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд хяналт шалгалт явуулж үнэлэх тухай “Цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах журам” (код 112)-д цагдаагийн газар, хэлтсийн үйл ажиллагааг үнэлж дүгнэх үзүүлэлт, аргачлалын загварт зарим өөрчлөлт оруулах шаардлагатай байна. Үүнд:

Удирдлагын үйл ажиллагааны чиглэлээр

- а. Хууль сахиулах ажиллагаанд сөргөөр нөлөөлж буй үзэгдлийг судалж, арилгах чиглэлээр зохион байгуулсан ажлын үр дүн;
- б. Тулгарсан асуудалд дүн шинжилгээ хийж, шийдвэрлэх арга замыг тодорхойлсон байдал;

- в. Орон нутгийн онцлогт тохирсон үйл ажиллагаа явуулсан байдал;
- г. Цагдаагийн стратеги, үйл ажиллагааны тэргүүлэх чиглэлийг хөгжүүлэх чиглэлээр тасаг нэгжийн үйл ажиллагааг мэргэжлийн удирдлагаар хангаж, бусдыг манлайлан удирдсан байдал гэсэн үзүүлэлтийг нэмэх.

Бодлого хэрэгжүүлэх чиглэлээр

- а. Нутаг дэвсгэрийн засаг захиргааны байгууллагатай хамтран ажиллах бодлогын баримт бичгийн дагуу ажилласан байдал;
 - б. Цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд шинжлэх ухааны ололт амжилт орчин үеийн техник технологи нэвтрүүлж ашиглах бодлогыг хэрэгжүүлсэн байдал;
 - в. Хүний эрхийг хангах бодлого боловсруулж хэрэгжүүлсэн байдал;
 - г. Хууль тогтоомж болон бодлогын хэрэгжилтийг тогтмол хянаж, илүү үр дүнтэй болгох талаар санал дэвшүүлж хэрэгжүүлсэн байдал;
 - д. Иргэд, оршин суугчдын хэрэгцээ шаардлагад нийцсэн зорилго, зорилт дэвшүүлж, хангасан байдал гэсэн үзүүлэлтийг нэмж оруулах санал дэвшүүлж байна.
6. Цагдаагийн алба хаагчдын ажил дүгнэх үзүүлэлтийг хүний эрхийн зарчимд нийцүүлэхтэй холбоотой дараах санал дэвшүүлж байна.

Удирдах албан тушаалтны ажил дүгнэх үзүүлэлтэд тусгавал зохих үзүүлэлт

- а. Хууль сахиулах ажиллагаанд нөлөөлж буй сөрөг үзэгдлийн талаар судалж, түүнийг арилгах чиглэлээр зохион байгуулсан ажлын үр дүн;
- б. Тулгарсан асуудалд дүн шинжилгээ хийж, шийдвэрлэх арга замыг тодорхойлсон байдал;
- в. Орон нутгийн онцлогт тохирсон үйл ажиллагаа явуулсан байдал;
- г. Цагдаагийн стратеги, үйл ажиллагааны тэргүүлэх чиглэлийг хөгжүүлэх чиглэлээр тасаг нэгжийн үйл ажиллагааг мэргэжлийн удирдлагаар хангаж, бусдыг манлайлан удирдсан байдал;

- д. Ард иргэдийн санал хүсэлтийг хүлээн авч, шийдвэрлэсэн байдал;
- е. Байгууллагынхаа хэмжээнд хүний эрхийг хангах чиглэлээр зохион байгуулсан ажил, үр дүн;
- ё. Байгууллагын бүх алба хаагчдын ур чадварыг дээшлүүлж, хөгжүүлэх боломжийг эрэлхийлж, сургалт зохион байгуулсан байдал;
- ж. Зэргэлдээ цагдаагийн байгууллагатай хамтран ажилласан байдал, үр дүн;
- з. Шинжлэх ухааны ололт амжилт, орчин үеийн техник технологи ашиглах бодлогыг хэрэгжүүлсэн байдал, үр дүн.

Мөрдөгч, эрүүгийн мөрдөгч нарын ажил дүгнэх үзүүлэлтэд тусгавал зохих үзүүлэлт

- а. Гэмт хэрэг илрүүлэлтийн хувь;
- б. Мөрдөн шалгах ажиллагааг хуулийн дагуу явуулсан байдал;
- в. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажил явуулсан байдал, түүний үр дүн;
- г. Хохирогчийн эрхийг хангах арга хэмжээ авсан байдал;
- д. Эрэн сурвалжлагдаж буй хүн, мал амьтан, эд зүйлийг олж тогтоосон байдал;
- е. Өөрийн санаачилгаар гүйцэтгэсэн ажил;
- ё. Илүү цагийн гүйцэтгэл.

Олон нийтийн аюулгүй байдлыг хангах, нийтийн хэв журам сахиулах албаны алба хаагчдын ажил дүгнэх үзүүлэлтэд тусгавал зохих үзүүлэлт

- а. Иргэдтэй зөв харилцдаг;
- б. Хуулийн дагуу үйл ажиллагаа явуулсан байдал;
- в. Тулгарсан асуудлыг эв зүйгээр шийддэг;
- г. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажил явуулсан байдал, түүний үр дүн;
- д. Гэмт хэргийн илрүүлэлтийн хувь;
- е. Хохирогчийн эрхийг хангах арга хэмжээ авсан байдал;
- ё. Хүний эрхийн зөрчлийг зохих байгууллагад мэдүүлсэн тоо;
- ж. Өөрийн санаачилгаар гүйцэтгэсэн ажил;
- з. Объектын болон субъектын судалгаа хийсэн байдал (баяжилт хийсэн байдал);

- и. Эрэн сурвалжлагдаж буй хүн, мал амьтан, эл зүйлийг олж тогтоосон байдал;
- к. Цагдаагийн бусад алба, нэгж, тасаг, хэсгээс зохион байгуулсан ажил арга хэмжээнд оролцсон байдал (нэгдсэн болон хэсэгчилсэн арга хэмжээ);
- л. Биеийн хүч, тусгай хэрэгслийг журмын дагуу ашигласан байдал;
- м. Илүү цагийн гүйцэтгэл.

Замын цагдаагийн албаны алба хаагчдын ажил дүгнэх үзүүлэлтэд тусгавал зохих үзүүлэлт

- а. Шалгасан тээврийн хэрэгслийн тоо;
 - б. Эрэн сурвалжлагдаж буй тээврийн хэрэгслийг олж илрүүлсэн байдал;
 - в. Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг зөрчсөн осол хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ, үр дүн;
 - г. Гэмт хэргийн илрүүлэлтийн хувь;
 - д. Зам тээврийн осол, хэргийн гаралтыг бууруулсан хувь;
 - е. Зам тээврийн осол, хэргийн илрүүлэлийн хувь;
 - ё. Иргэдтэй зөв харилцдаг;
 - ж. Хуулийн дагуу үйл ажиллагаа явуулдаг;
 - з. Тулгарсан асуудлыг эв зүйгээр шийддэг;
 - и. Илүү цагаар ажилласан цаг;
 - к. Биеийн хүч, тусгай хэрэгслийг журмын дагуу ашигласан байдал.
7. Ажил дүгнэх үзүүлэлтийг сайжруулахтай холбоотой санал
- а. Ажил дүгнэх үзүүлэлтийг тухайн алба хаагчдын гүйцэтгэж буй үүрэг, алба хаагчдын ажлын байрны тодорхойлолттой нийцүүлэх;
 - б. Хамт ажилладаг албан хаагч буюу ахлах байцаагчаас санал авч, тухайн алба хаагчдын хийсэн ажлыг үнэн зөв, бодитой дүгнэх;
 - в. Ажлыг өдрөөр биш цагаар тооцох, гэмт хэрэг зөрчил гараагүй тохиолдолд ажлын үзүүлэлтийг дээгүүрт авч үзэх;
 - г. Гүйцэтгэсэн ажлын тоо хэмжээ бус хийсэн ажлын чанар, үр дүнгээр дүгнэх
 - д. Өөр өөр албан тушаалд ажиллаж буй алба хаагчдын ажлыг нэг шалгуур үзүүлэлтээр бус өөр өөр шалгуур үзүүлэлтээр дүгнэх;

- е. Торгож шийтгэхэд бус, урьдчилан сэргийлэх ажлын үр нөлөөг чухалчлах.
8. Ажил дүгнэх үзүүлэлтэд нэмж тусгахтай холбоотой санал
- а. Ажлын үр дүнг тухайн алба хаагчийн хийсэн ажлын үр дүнгээр тооцож, ажлаас гадуурх олон нийтийн ажлыг тооцох;
 - б. Бүх алба хаагчдын ажил дүгнэх үзүүлэлтэд урьдчилан сэргийлэх ажил явуулсан байдлыг нэмж тусгах;
 - в. Иргэдтэй зөв харилцдаг;
 - г. Мөрдөн байцаалтыг шударга гүйцэтгэдэг;
 - д. Хуулийн дагуу үйл ажиллагаа явуулдаг;
 - е. Тулгарсан асуудлыг эв зүйгээр шийддэг;
 - ё. Хохирогчдын эрхийг хангах арга хэмжээ авсан байдал;
 - ж. Хүний эрхийн зөрчлийг зохих байгууллагад мэдүүлсэн тоо;
 - з. Өөрийн санаачилгаар гүйцэтгэсэн ажил;
 - и. Объект, субъектийн судалгаа явуулсан байдал;
 - к. Эрэн сурвалжлагдаж буй этгээдийг олж тогтоосон байдал.
9. Ажил дүгнэх үзүүлэлтээс зарим үзүүлэлтийг хасахтай холбоотой саналтай
- а. Гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам сахиулах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах чиг үүрэг гүйцэтгэж буй алба хаагчдаас бусад алба хаагчийг гэмт хэргийн талаар илтгэх хуудас бичиж өгөх үүргээс чөлөөлөх;
 - б. Шийтгэврийн хуудас, тасалбараар торгууль ногдуулсан гэсэн үзүүлэлтийг хасах;
 - в. Мөрдөгчийн яллах дүгнэлт үйлдүүлэхээр шилжүүлсэн хэргийн тоон үзүүлэлтийг хасах;
 - г. Алба хаагчдын үндсэн чиг үүрэгт хамааралгүй ажлыг хасах;
 - д. Эрүүлжүүлсэн хүний тоо гэсэн үзүүлэлтийг хасах.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

Хууль тогтоомж, дүрэм журам

1. Монгол Улсын Үндсэн хууль
2. Цагдаагийн албаны тухай хууль
3. Хөдөлмөрийн хууль
4. Төрийн албаны тухай хууль
5. Цагдаагийн байгууллагын үйл ажилгааны журам
6. Цагдаагийн хэв журмын албаны алба хаагчдын ажил дүгнэх үзүүлэлт
7. Цагдаагийн мөрдөх албаны алба хаагчдын ажил дүгнэх үзүүлэлт
8. Замын цагдаагийн албаны алба хаагчдын ажил дүгнэх үзүүлэлт

Ном бүтээл илтгэл өгүүлэл

9. Б.Алтанбагана, Т. Гантулга. Хүч ба галт зэвсэг хэрэглэх нь, УБ хот, 2007.
10. Х.Виктор, Кондэ, Хүний эрхийн Олон улсын нэр томъёоны гарын авлага, УБ, 2016.
11. Л.Сүхээ, Хүний эрх - цагдаагийн хэрэг бүртгэлт. (“Хүний эрх - хэрэг бүртгэх ажиллагаа” сэдэвт зөвлөгөөн дээр тавьсан илтгэл). Хэрэг бүртгэх ажиллагаа. Эмхэтгэл. УБ., 2005. 16 дахь тал
12. Хүний эрхийн түгээмэл тунхаглал батлагдсаны 60 жил жилийн ойн хүрээнд Хүний эрх, эрх чөлөөг хангах талаар хийсэн ажлын талаарх Цагдаагийн ерөнхий газрын мэдээлэл, Хүний эрх сэтгүүл, 2008, №3
13. Хохирогчийн эрхийн баталгаа сэдвээр зохион байгуулсан үндэсний чуулганаас гаргасан зөвлөмжийн хэрэгжилт, үр дүн, ХЗДХЯ-ны төрийн нарийн бичгийн дарга Г.Баясгалангийн илтгэл, Хүний эрх сэтгүүл, 2008, № 4
14. Хүний эрхийн конвенцуудын хорооноос батлан гаргасан ерөнхий санал, зөвлөмжүүдийн Эмхэтгэл, УБ хот, 2004.
15. ХСИС-ийн Хүний эрх ба хууль сахиулах ажил хичээлийн хөтөлбөр, 2015.
16. Хүний эрх, олон улсын гэрээ хэлэлцээрүүдийн Эмхэтгэл, 1992, 1998.
17. Хүний эрхийг хангах практик үйл ажиллагаа, 2015.
18. Хууль сахиулахын их сургуулийн Эрдэм шинжилгээ хөгжлийн хүрээлэнгийн 2012-2016 оны эрдэм шинжилгээний тайлан

Сэтгүүл

19. Хүний эрх
20. Монголын төр эрх зүй
21. Эрх зүй
22. Гэмт явдалтай тэмцэх асуудал
23. Өмгөөлөгч
24. Хууль дээдлэх ёс

25. Хууль сахиулахуй

26. Цагдаа судлал

Цахим хуудас

Legalinfo.mn

<http://www.policeforum.org>

<http://www.policemag.com>

<http://www.ohchr.org>

<http://wispindex.org>

Гадаад хэл дээрх материал

WISPI Report

Police practice

Police Chief Performance Evaluation

Personnel performance evaluations in the community policing context